

COVID-19-ИЙН ХЯМРАЛЫН ДАРААХ НОГООН ШИЛЖИЛТ, ИННОВАЦЫН ЧИГЛЭЛЭЭР БЖДБЭ-ИЙН ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ ХЭРЭГЦЭЭНИЙ ҮНЭЛГЭЭ

Хэрэгцээ тодорхойлох судалгааны тайлан



© 2023 Байгаль Орчин, Уур Амьсгалын Өөрчлөлтийн Яам

15141 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Барилгачдын талбай-3, Засгийн газрын 12 дугаар байрны 4 дүгээр давхар

Энэхүү тайланг Байгаль Орчин, Уур Амьсгалын Өөрчлөлтийн Яамны захиалгаар, Азийн Хөгжлийн Банкны санхүүжилтээр хэрэгжиж буй ТТ-6883 REG: Зүүн Азид жендэрийн тэгш байдлыг хурдасгах – Хүртээмжтэй, ногоон сэргэлтийн төлөө бүсийн техникийн туслалцааны төслийн хүрээнд хамтарсан зөвлөх үйлчилгээний баг боловсруулав.

Уг тайланд ашигласан мэдээлэл, материал, тоо баримт, судалгааны үр дүн, дүгнэлт эсвэл дээрх дурдагдсан зүйлсийг гуравдагч этгээдийн ашигласан байдал, түүнээс гарах үр дүнгийн талаар шууд болон шууд бус хэлбэрээр ямар нэгэн баталгаа гаргахгүй бөгөөд судалгааны үр дүн нь яамны байр суурийг илэрхийлэхгүй бөгөөд зөвлөх үйлчилгээний багийн үзэл санаа юм.

Тайланг боловсруулсан: IRIM судалгааны хүрээлэн, Хөгжлийн Шийдэл ТББ, Монголын Тогтвортой Санхүүгийн холбоо ТББ -ын хамтарсан зөвлөх үйлчилгээний баг

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ	2
ХҮСНЭГТ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ	3
ХУРААНГУЙ.....	4
1. Аргагүй	6
1.1. Судалгааны зорилго	6
1.2. Хамрах хүрээ ба зорилтот хүн ам.....	6
1.3. Судалгааны түүврийн хамрах хүрээ, хэмжээ.....	7
1.4. Судалгааны үе шат, зохион байгуулалт	8
1.5. Судалгааны хязгаарлагдмал тал:.....	9
2. Зах зээлийн тойм	10
2.1. Хоол хүнс, ундаа, сав баглаа боодлын нийлүүлэлт	10
2.2. Хоол хүнс, ундаа, сав баглаа боодлын эрэлт	12
3. Сорилт ба боломжууд.....	13
4. Бизнес эрхлэгчдийн ТЭЗ-ийн талаарх хэрэгцээ шаардлага	19
4.1. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл.....	19
4.2. Бизнесийн нийтлэг үйл ажиллагаа	20
4.3. Тойрог эдийн засгийн талаарх бизнес эрхлэгчдийн хэрэгцээ, шаардлага	23
4.3.1. Тойрог эдийн засгийн талаарх мэдлэг	23
4.3.2. Тойрог эдийн засгийн талаарх хандлага	25
4.3.3. Тойрог эдийн засгийн талаарх туршлага.....	28
4.3.4. Тойрог эдийн засгийн боломжуудыг нэвтрүүлэхэд тулгарч буй саад бэрхшээлүүд	29
4.3.5. Тойрог эдийн засгийн талаарх сургалт, дэмжлэгийн хэрэгцээ	31
4.3.6. Сургалтын зохион байгуулалт.....	34
4.3.7. Хүлээлт.....	35
5. Дүгнэлт ба зөвлөмж.....	37
6. Хавсралтууд.....	38
Хавсралт 1—Сайн жишээ болох кейсүүд.....	38

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

БЖДБЭ	Бичил, жижиг, дунд бизнес эрхлэгч
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
ГЯ	Ганцаарчилсан ярилцлага
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
МҮХАҮТ	Монголын үйлдвэр, худалдаа, аж үйлдвэрийн тэнхим
НӨАТ	Нэмүү өртгийн албан татвар
ТББ	Төрийн бус байгууллага
ТоС холбоо	Монголын тогтвортой санхүүжилтийн холбоо
ТЭЗ	Тойрог эдийн засаг
УАНС	Уур амьсгалын ногоон сан
ХШҮ	Хяналт, шинжилгээ, үнэлгээ

ХҮСНЭГТ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Судалгааны үе шат болон мэдээлэл цуглуулсан арга	7
Зураг 2. Нэн тэргүүн хэрэгжүүлэх ажлын саналууд	16
Зураг 3. Салбарын хувьд тулгамдаж буй асуудлууд	17
Зураг 4. Шалтгаан, үр дагаврын диаграм	17
Зураг 5. Судалгаанд оролцогчдын амьдардаг газар болон бизнес эрхэлдэг газар	19
Зураг 6. Насны бүтэц, %	19
Зураг 7. Боловсролын түвшин, %	19
Зураг 8. Судалгаанд оролцогчдын албан тушаал, %	20
Зураг 9. Үйл ажиллагааны чиглэл, %	20
Зураг 10. Бизнесийн үйл ажиллагаа эрхэлсэн жил, %	21
Зураг 11. Ажилтны тоо, %	21
Зураг 12. Бизнес эрхлэгчдийн ТЭЗ-ийг талаарх ойлголтоо тодорхойлсон байдал	24
Зураг 13. ТЭЗ-ийг улсдаа болон салбартаа нэвтрүүлэх нь ач холбогдолтой эсэх	26
Зураг 14. Бизнесээ цаашид байгальд ээлтэйгээр хөгжүүлэх сонирхол	26
Зураг 15. ТЭЗ-ийн хөгжлийн ойрын 5 жилийн төсөөлөл	27
Зураг 16. ТЭЗ-ийг хөгжүүлэхэд шаардагдах хүчин зүйлсэд өгч буй ач холбогдол	27
Зураг 17. Бизнес нь ТЭЗ-тай холбогдох бодлогын баримт бичиг байгаа эсэх, байгаа бол боловсруулсан шалтгаан	28
Зураг 18. ТЭЗ-ийг өөрийн бизнестээ нэвтрүүлэхийг хүсэж буй чиглэл	31
Зураг 19. ТЭЗ-ийн шийдлүүдийн талаарх сургалт, зөвлөх үйлчилгээний хэрэгцээ	33
Зураг 20. ТЭЗ-ийн шийдлүүдийг ашиглахад шаардагдах дэмжлэгийн хэрэгцээ	34
Зураг 21. Сургалт зохион байгуулах аргачлал, %	35
Зураг 22. Сургалт, зөвлөгөөний мэдээлэл хүлээн авах суваг, %	35
Зураг 23. ТЭЗ-ийн загварт шилжсэнээр гарах өөрчлөлтийн талаарх төсөөлөл	36
 Хүснэгт 1. Тоон судалгааны түүврийн хэмжээ	7
Хүснэгт 2. Аялал жуулчлалын салбарын БЭ-дэд цар тахлын үзүүлж буй нөлөө судалгаа	13
Хүснэгт 3. БЖДБЭ-д дэд салбарт нөлөөлж буй дотоод хүчин зүйлс	15
Хүснэгт 4. Бизнесийн жилийн эргэлтийн хөрөнгө 2022 он	21
Хүснэгт 5. Мэдлэгийн түвшнийг байгууллагын зарим үзүүлэлтээр	23
Хүснэгт 6. ТЭЗ-ийн талаар мэдлэгтэй эсэх	24
Хүснэгт 7. Бизнестээ ТЭЗ-ийг нэвтрүүлэхэд тулгарч буй бэрхшээл	29
Хүснэгт 8. Сургалт, зөвлөх үйлчилгээний хэрэгцээг бүлгээр харьцуулсан мэдээлэл	31
Хүснэгт 9. Сургалт зөвлөх үйлчилгээний сэдвүүдийг бизнес эрхлэгчдийн бүлэг, үзүүлэлтээр харьцуулсан мэдээлэл	33

ХУРААНГУЙ

Аялал жуулчлалын салбар, хүнс, сав баглаа боодлын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй бизнес эрхлэгчдийг чадавхжуулах зорилготой “Тойрог эдийн засаг (ТЭЗ) ба ногоон бизнесийн чиглэлд БИЧИЛ, ЖИЖИГ ДУНД БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙГ чадавхжуулах” зөвлөх үйлчилгээг Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ)-ны захиалга, Азийн Хөгжлийн Банк (АХБ)-ны дэмжлэгтэйгээр IRIM, ToC Холбоо, Хөгжлийн шийдэл ТББ, олон улсын зөвлөх үйлчилгээний байгууллага болох Adelphi хамтарсан төслийн баг 2022 оны 11 сараас 2024 оны 05 сарын хугацаанд хэрэгжүүлж байна. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь гурван бүрэлдэхүүний хүрээнд хийгдэх ба бүрэлдэхүүн 1-ийн хүрээнд цогц үнэлгээг зохион байгуулж байгаа юм. Уг тайлангаар цогц үнэлгээний нэг хэсэг болох зорилтот салбарын эмэгтэй удирдлагатай бизнесүүдийн ТЭЗ-ийн талаар чадавхжих хэрэгцээг тодорхойлсон судалгааны үр дүнг танилцуулж байна. Судалгааны үр дүнд тулгуурлан зөвлөх баг нь чадавхжуулах сургалт, зөвлөгөөний үйл ажиллагааны сэдэв, хөтөлбөрийг төлөвлөн хэрэгжүүлэх юм.

Үндэсний статистикийн хорооны 2021 оны аж ахуйн нэгжийн тооллогын урьдчилсан дүнгээр Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй нийт аж ахуйн нэгжийн 38% нь эмэгтэй захиралтай байна. Харин жижиг, дунд үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа эрхэлж буй бизнес эрхлэгчдийн 60 гаруй хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаа юм. Гэвч эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин сүүлийн жилүүдэд буурах хандлагатай байна. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны мэдээлснээр аялал жуулчлалын салбарын 70 орчим хувийг бичил, жижиг, дунд бизнес эрхлэгч (БЖДБЭ)-д эзэлдэг. Нийт БЖДБЭ-дийн 25.9% (2,134) нь зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарт, 6.6% (57) нь боловсруулах үйлдвэрлэлд үйл ажиллагаа эрхэлдэг.

Бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд КОВИД-19 цар тахал хэрхэн нөлөөлсөн талаар олон тооны судалгаа энэ хугацаанд хийгдсэн. Тухайлбал, КОВИД-19 цар тахал бизнесүүдийн үйл ажиллагаанд ихээхэн сөргөөр нөлөөлсөн ба ялангуяа аялал жуулчлалын салбар болон хоол үйлдвэрлэлийн салбарт хамгийн ихээр нөлөөлсөн буюу 83%-аар нөлөөлсөн байна¹. Түүнчлэн, БЖДБ-дэд тулгардаг хамгийн том бэрхшээл нь санхүүжилт, өрсөлдөх чадавх зэрэг нь үйл ажиллагаагаа өргөжүүлэх, зах зээлээ тэлэх, цаашлаад ногоон эдийн засгийн туршлагаудыг нэвтрүүлэх боломжийг хязгаарлагдмал болгодог. Тиймээс цар тахлын дараах сэргэлтийн шатанд эдгээр салбаруудад техник туслалцааны дэмжлэг ихээхэн чухал бөгөөд ингэхдээ тогтвортой, байгальд ээлтэй, ТЭЗ-ийг үйл ажиллагаанд нэвтрүүлэхэд дэмжих нь чухал юм.

Судалгааны үр дүнг 400 зорилтот салбарын бизнес эрхлэгчдийн тоон судалгаа, баримт бичгийн шинжилгээ, оролцогч талуудын ярилцлага, кейс зэрэг чанарын мэдээлэлд тулгуурлан боловсруулав. Тоон судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгчдийн 80.5% нь эмэгтэй, үлдсэн 19.5% нь эрэгтэй байна. Нийт түүврийг бүрдүүлэхдээ төсөл хэрэгжих зорилтот байршлууд болох Улаанбаатараас 76.5%-ийг, Хөвсгөл аймгаас 13.5%-ийг, Архангай аймгаас 10%-ийг хамрууллаа. Үйл ажиллагааны чиглэлээр харвал 1/3 нь аялал жуулчлалын бааз, зочид буудал зэрэг байраар хангах үйлчилгээ үзүүлэгчид, 1/3 нь хоол үйлдвэрлэл, үйлчилгээ үзүүлэгчид, үлдсэн 1/3 нь бусад зорилтот салбар болох хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ үзүүлэгчид, сав баглаа боодол үйлдвэрлэл, хүнсний дэлгүүр зэрэг салбарынхан байна.

Бизнес эрхлэгчдийн ТЭЗ-ийн талаарх хэрэгцээг судлахын тулд мэдлэг, хандлага, туршлагын түвшнийг эхлээд тодорхойлсон. Тэдний 6.5% нь л ТЭЗ-тай холбогдох ойлголтыг сайн мэднэ, 66.8% нь сонсож байсан, 26.8% нь огт сонсож байгаагүй гэжээ. Ойлголтын түвшин нь боловсролын байдал болон өмнө нь энэ чиглэлийн сургалтад хамрагдаж байсан эсэхээс хамаарсан ялгаатай байна. Бизнес эрхлэгчдийн

¹ Бизнесийн Салбаруудад КОВИД-19 Цар Тахлын Үзүүлсэн Нөлөөлөл 2020-2021 - БОАЖЯ

96% нь ТЭЗ-ийг салбартаа нэвтрүүлэх нь ач холбогдолтой гэж үзэн, цаашид энэ төрлийн үйл ажиллагааг бизнестээ нэвтрүүлэх сонирхол өндөр (91.3%) байгаагаа илэрхийлсэн. Ердөө 2.3% нь сонирхолгүй болон хэлж мэдэхгүй гэсэн хариулт өгсөн. Тэд цаашдаа ТЭЗ хөгжих нь тодорхой боловч өөрийн бизнесийн салбарт дахь ойрын таван жилийн хугацааны хөгжлийг ихэвчлэн сайн болон дунд түвшинд хөгжсөн байна гэж төсөөлж байна. Бизнес эрхлэгчдийн ихэнх нь "хогоо ангилах, дахин боловсруулах" төдийгөөр л ТЭЗ-ийг ойлгож байгаа нь цаашид энэ чиглэлд үйл ажиллагаагаа сайжруулах сонирхолтой байгаатай шууд холбогдож байна.

Судалгаанд хамрагдсан бизнесүүдийн тал хувь нь (49.8%) байгаль орчинд ээлтэй, ногоон, хаягдалгүй (ТЭЗ) бизнесийн үйл явцыг ямар нэг хэмжээгээр үйл ажиллагаандаа ашигладаг гэжээ. Тухайлбал, бүтээгдэхүүн үйлчилгээндээ байгалийн гаралтай материал ашигладаг, хог хаягдлыг бордоо болон малын тэжээл болгодог, хог хаягдлыг дараагийн шатны боловсруулах үйлдвэрт өгдөг гэх мэт олон төрлийн үйл ажиллагааг нэрлэсэн. Гэхдээ 17%-д нь л байгаль орчинд ээлтэй, ногоон, хаягдалгүй үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэхэд чиглэсэн бодлогын баримт бичиг, төсөв, төлөвлөгөөтэй байна. Судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгчдийн 31.5% нь сүүлийн 5 жилийн хугацаанд байгальд ээлтэй ТЭЗ-ийн чиглэлээр ямар нэг тоног төхөөрөмж, технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн бизнесийг мэднэ гэж хариулсан. Тэд бизнесийн үйл ажиллагаагаа байгаль орчинд ээлтэй, ногоон хаягдалгүй байдлаар хэрэгжүүлэхэд өөрсдөдөө тулгардаг саад бэрхшээлүүдээс дараах зүйлс хамгийн ихээр тулгамддаг гэж үзсэн. Үүнд:

1. Эдийн засаг, санхүүгийн нөөц дутагдалтай, дэмжлэг авах боломж хязгаарлагдмал - 59.0%
2. Хөрөнгө оруулалт дутмаг - 52.0%
3. Байгальд ээлтэй технологийн сүүлийн үеийн хөгжил, тойрог эдийн засгийн талаарх дэлхий, бүс нутаг, үндэсний чиг хандлагатай холбоотой мэдээллийн хүртээмж муу - 49.5%
4. ТЭЗ, түүнийг хэрэгжүүлэх дизайн, стратеги, шийдэлтэй холбоотой мэдээлэл дутмаг - 46.3%
5. Одоогийн хууль тогтоомжийн дэмжлэг, урамшуулал, хөшүүрэг тун муу - 44.0%

Бизнесүүд ТЭЗ-ийн чиглэлээр чадавхжих сургалт, зөвлөх үйлчилгээ, дэмжлэгийн хэрэгцээ нь дээрх тулгамдаж буй асуудлуудтай шууд уялдаатай байна. Тодруулбал, юун түрүүнд ТЭЗ-ийн шийдлүүдийг өөрийн бизнесийн үйл ажиллагаанд нэвтрүүлэхэд санхүүгийн нэмэлт эх үүсвэр шаардлагатай гэж 90% гаруй нь онцолжээ. Ялангуяа тогтвортой, ногоон санхүүжилтийн талаарх мэдлэг, мэдээлэл хомс байдаг нь судалгааны үр дүнгээр харагдсан. Үүний дараа хог хаягдлын менежменттэй холбоотой хэрэгцээ 89%, энэ чиглэлд үйл ажиллагаа явуулдаг байгууллага, үйл ажиллагааны талаар мэдээллийн хэрэгцээ 87.7%-тай байв. Одоогийн нөхцөлд бизнесүүдийн ихэнх нь хог хаягдлыг ангилах, дахин боловсруулах ямар боломжууд байгаа талаар мэдлэг, мэдээлэл хомс учраас хог хаягдлаа хогийн цэг дээр төвлөрүүлж, ачуулах төдийгөөр шийдэж байна. Мөн ТЭЗ гэж юу болох, ямар ойлголт, үйл ажиллагааг хамруулан ойлгодог талаарх ерөнхий мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх хэрэгцээтэй (87.7%) байна. Энэ төрлийн ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлснээр бизнесийн үйл ажиллагаандаа хэрхэн нэвтрүүлэх боломжтой талаар тодорхой ойлголттой болно гэж үзэж байна. Тиймээс сургалт, зөвлөгөөг илүү практик болон туршлагад суурилан зохион байгуулах нь үр дүнтэй гэж судалгаанд оролцогчид үзсэн.

Бизнес эрхлэгчид ТЭЗ-ийг үйл ажиллагаандаа нэвтрүүлснээр нийгмийн хариуцлагаа нэмэгдүүлж, бусдад үлгэр дуурайл болно гэсэн төсөөлөл хамгийн их 67.3% байна. Үүний дараа ашиглалтын зардал буурна 47.3%, үйлдвэрлэл, үйлчилгээний зардал буурна 46.5%, нэр хүнд өснө 45.3%, борлуулалтын орлого нэмэгдэнэ 45% гэсэн хүлээлт хамгийн их байна.

1. Аргазүй

1.1. Судалгааны зорилго

Аялал жуулчлалын салбар дахь үйлчилгээ болон хүнс, сав баглаа боодлын салбарт үйл ажиллагаа эрхэлж буй БЖДБЭ-дэд тойрог эдийн засгийн бүтээгдэхүүн хөгжүүлэх, шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэхэд шаардлагатай мэдлэг болон дэмжлэгийн хэрэгцээг тодорхойлох нь энэхүү судалгааны ажлын гол зорилго юм.

Зорилтот салбарын БЖДБЭ-ээс авах судалгааг хосолмол дизайн ашиглан өргөн хүрээнд боловсруулсан ба нийт 400 бизнес эрхлэгчийг хамруулав. Тэднээс дараах агуулгын хүрээнд мэдээлэл цуглуулав. Үүнд:

- i. БЖДБЭ-ийн тойрог эдийн засгийн бэлэн байдлын үнэлгээ
- ii. БЖДБЭ-ийн тойрог эдийн засгийн талаар мэдлэг, хандлага, дадлыг тодорхойлох
- iii. Тойрог эдийн засгийн талаарх сургалт, зөвлөх үйлчилгээ болон бусад дэмжлэгийн хэрэгцээг тодорхойлох
- iv. Төслийн хяналт шинжилгээ үнэлгээ (ХШҮ)-ний хүрээний дагуух суурь шалгуур үзүүлэлтийг тодорхойлно.

БЖДБЭ-ээс авсан судалгаа нь эдгээр олон асуудлыг тодруулахыг зорьж энэхүү тайландаа БЖДБЭ-д тойрог эдийн засгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх чиглэлээрх сонирхол, хэрэгцээ, дэмжлэгийг тусгахыг зорьсон.

Уг тайлангийн үр дүнд тулгуурлан зөвлөх үйлчилгээний Бүрэлдэхүүн 2-т төлөвлөсөн тойрог эдийн засгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх чиглэлээрх БЖДБЭ-ийг чадавхжуулах сургалт, зөвлөгөөнд шаардлагатай мэдээллээр хангах юм.

1.2. Хамрах хүрээ ба зорилтот хүн ам

Судалгааны хамрах хүрээ, байршлыг сонгохдоо Азийн Хөгжлийн Банк (АХБ)-аас боловсруулсан ажлын даалгавар болон Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ)-ны саналыг харгалзан Архангай, Хөвсгөл болон Улаанбаатар бүс орчимд үйл ажиллагаа явуулж буй аялал жуулчлалын болон хүнс, сав баглаа боодлын салбарт үйл ажиллагаа эрхэлж буй БЖДБЭ-дийг тоон судалгаанд хамруулсан. Мөн чанарын судалгаанд холбогдох төрийн байгууллага, хувийн хэвшлийн байгууллага, холбоо, төрийн бус байгууллага болон олон улсын ижил төстэй төслүүдийн төлөөлөлтэй ганцаарчилсан ярилцлага хийсэн.

Судалгааг зохион байгуулсан үе шат болон аргыг дор харуулав

Зураг 1. Судалгааны үе шат болон мэдээлэл цуглуулсан арга



1.3. Судалгааны түүврийн хамрах хүрээ, хэмжээ

Тоон судалгаанд төслийн зорилтод 3 бүсийн 400 бизнес эрхлэгчдийг судалгаанд хамруулахдаа дараах шалгууруудыг ашигласан. Үүнд:

- Тухайн бизнес эмэгтэй эзэнтэй (50%-аас доошгүй хувьцаа) байх
- Тухайн бизнесийн удирдах ажилтан эмэгтэй (захирал эсвэл ТУЗ дарга) байх

Чанарын судалгаанд нийт 29 ганцаарчилсан ярилцлага хийсэн. Чанарын судалгааны түүвэрт төслийн зорилтот салбар болох аялал жуулчлалын салбарын хоол хүнс, сав баглаа боодлын үйлдвэрлэл, үйлчилгээтэй хамаарал бүхий үндэсний хэмжээний болон орон нутгийн төрийн байгууллагууд, төрийн бус байгууллагууд гэх мэт олон талт бүлгүүдийг хамруулав.

Хүснэгт 1. Тоон судалгааны түүврийн хэмжээ

№	Ангилал	Үүнээс, байршлаар			Нийт
		Улаанбаатар бүс орчмын	Архангай	Хөвсгөл	
Тоон судалгааны түүвэр					
1	Хүнс болон шингэн хүнсний үйлдвэрлэл	68	4	6	78
2	Хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид	101	10	27	138
3	Сав баглаа боодлын үйлдвэрлэл эрхлэгчид	6	0	0	6
4	Байраар хангах үйлчилгээ үзүүлэгчид	87	26	15	128
5	Хоол, ус ундаагаар хангах үйлчилгээ үзүүлэгчид	12	4	0	16
6	Хүнсний дэлгүүр	16	8	10	34
Нийт		290	52	58	400
Чанарын судалгааны түүвэр					
7	Төрийн байгууллага	5	3	2	10
8	Хувийн хэвшил	5	1		6
9	Олон улсын төсөл, хөтөлбөр	4			4
10	Академик болон Сургалт, судалгааны байгууллагууд	3			3
	ТББ, холбоод	5	1		6
Нийт		22	5	2	29

Мөн Монгол дахь сайн туршлага бүхий жишээ кейс судлах зорилгоор 2 бизнес эрхлэгчтэй уулзсан. Үүнд дараах байгууллагууд хамрагдсан:

№	Байгууллагууд	Үйл ажиллагааны чиглэл	Сонгосон шалтгаан
1	Jamo Grand LLC	Жуулчны бааз	ТЭЗ-ийн 5R зарчмыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлдэг. Үүнд, худалдан авалт хийх, байр хоолоор үйлчлэх зэрэг үйл ажиллагааны бүх шатанд хог хаягдлыг хамгийн бага түвшинд байлгах, эрчим хүч, ус хэмнэх байгальд ээлтэй шийдэл, стандарт, туршлагуудыг хэрэгжүүлдэг.
2	DMD LLC	Тур оператор, жуулчны бааз	Ямар нэгэн бетонон байгууламж, хуванцар эд хэрэглэлээс ангид байгалийн гаралтай материалаар хийсэн, хог хаягдал бага гаргадаг, усны хэмнэлттэй нүүдлийн жуулчны бааз ажиллуулдаг. Байгальд ямар нэгэн ул мөр үлдээлгүй аялахыг эрмэлздэг жуулчдын сонирхлыг их татдаг.

Үр дүнгийн хураангуй тэмдэглэлийг Хавсралт 1-ээс үзнэ үү.

1.4. Судалгааны үе шат, зохион байгуулалт

Судалгааны ажлыг нь 2023 оны 03 сараас 2023 оны 05 дүгээр сарыг дуустал дараах 3 үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

1. **Эхлэлтийн үе шат:** Эхлэлтийн тайланд дурдсан арга зүй, хэрэглэгдэхүүнд захиалагчийн саналыг тусгаж эцэслэсний дараа талбарын мэдээлэл цуглуулалтын бэлтгэлийг эхлүүлж, туршилт судалгаа болон судлаачдын сургалтыг зохион байгуулав. Хэрэглэгдэхүүн батлагдсаны дараа дараах ажлууд эхлэлтийн шатанд хийгдсэн.

i. **Туршилт судалгааг** төслийн үндсэн баг талбарт гүйцэтгэсэн. Туршилтын үр дүнг үндэслэн захиалагч болон судалгааны баг хэрэглэгдэхүүнд оруулах өөрчлөлтийг хэлэлцэж, эцэслэсэн. Талуудын саналууд болон туршилт судалгааны үр дүнг тусгасан хэрэглэгдэхүүний эцсийн хувилбарыг захиалагч талаас баталж зөвшөөрөл өгснөөр мэдээлэл цуглуулалтыг эхлүүлсэн.

ii. **Судлаачдын сургалт.** Тоон судалгааны мэдээлэл цуглуулах судлаачдад судалгааны зорилго, мэдээлэл цуглуулах арга, хэрэглэгдэхүүнийг таниулахын тулд 3-р сарын 22-ны өдөр “Судлаачдын сургалт” зохион байгуулсан. Сургалтын үеэр мэдээлэл цуглуулалтын дадлага ажил хийлгэж, сургалтын агуулгыг бататгах “Мэдлэг шалгах тест” бөглүүлэх байдлаар сургалтад хамрагдсан судлаачдын мэдлэг, ойлголтыг бататгах ажлыг зохион байгуулсан.

2. **Мэдээлэл цуглуулалтын үе шат:** Тоон мэдээлэл цуглуулалт 3-р сарын 24-өөс 4-р сарын 15-ны хооронд зорилтот 3 байршилд явагдсан. Талбарт нийтдээ 10 судлаач ажилласан.

i. Чанарын мэдээлэл цуглуулалт буюу ярилцлагыг зөвлөх үйлчилгээний багийн гишүүд өөрсдөө биечлэн гүйцэтгэсэн.

ii. Мэдээллийг цуглуулсны дараа цугларсан мэдээллийг цэвэрлэж, утсан хяналт болон бичлэг тулгах чанарын хяналтыг хийж гүйцэтгэсэн.

3. **Тайлан боловсруулах, төгсгөлийн шат:** Энэхүү үнэлгээний хүрээнд цугларсан тоон болон чанарын мэдээллийг боловсруулахдаа нийгмийн шинжлэх ухаанд ашигладаг статистикийн багц программ SPSS 26.0 болон atlas.ti программыг ашигласан. Эцсийн тайлангийн хүрээг урьдчилж захиалагчаар батлуулсан бөгөөд хүрээний дагуу төслийн үндсэн баг хэрэгцээ тодорхойлох судалгааны эцсийн тайланг боловсруулсан.

1.5. Судалгааны хязгаарлагдмал тал:

Зорилтот салбаруудын зарим нь улирлын чанартай учир олоход хүндрэлтэй байв. Мөн үйл ажиллагаа нь эхлээгүй учир ажлын байраар нь зочлох, ажиглалт хийх боломж хязгаарлагдмал байсан. Тийм учраас ажиглалтыг судлаачид ерөнхий байдлаар тэмдэглэж байсан.

2. Зах зээлийн тойм

2019 оны байдлаар аялал жуулчлалын салбар нь ДНБ-ий 6,7%-ийг, хөдөлмөр эрхлэлтийн 7,2%-ийг бүрдүүлж нийт 1,8 их наяд төгрөг (ойролцоогоор 670 сая ам. доллар)-ийн орлоготой ажиллаж байсан Монгол Улсын эдийн засгийн чухал салбар юм². Гэвч КОВИД-19 цар тахлын нөлөөгөөр энэ үзүүлэлт буурсан ч эргэн сэргэж эхэлж байна. Аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа эрхэлдэг хоол хүнс, ус ундаа, сав баглаа боодлын үйлдвэрлэлийн салбар жил бүр дэлхийн өнцөг булан бүрээс Монгол Улсад ирэх 500,000 гаруй жуулчдын хэрэгцээг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг хэдий ч хүлэмжийн хийн ялгарал, хог хаягдал зэргээрээ байгаль орчинд ихээхэн сөрөг нөлөө үзүүлдэг салбаруудын нэг³. Аялал жуулчлалын салбарын хоол хүнс, ус ундаа, сав баглаа боодлын салбар нь зочид буудал, жуулчны бааз, ресторан, зоогийн газар, кафе зэрэг хоол боловсруулах болон сав баглаа боодлын үйлдвэрлэлүүд гэх мэтчилэн олон төрлийн бичил, жижиг, дунд үйлдвэр болон бизнес эрхлэгчдийг (БЖДБЭ) хамардаг. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны мэдээлснээр аялал жуулчлалын салбарын 70 орчим хувийг БЖДБЭ-д эзэлдэг⁴. 2021 оны статистик мэдээллээр нийт БЖДБЭ-дийн 25,9% (2,134) нь зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарт, 6,6% (57) нь боловсруулах үйлдвэрлэлт үйл ажиллагаа эрхэлдэг⁵ бөгөөд аялал жуулчлалын салбарт нийтдээ 520 зочид буудал, 526 жуулчны бааз, 200 зоогийн газар үйл ажиллагаа явуулдаг байна⁶. Гэвч Байгаль орчин, аялал жуулчлалын яамны "Бизнесийн Салбаруудад КОВИД-19 Цар Тахлын Үзүүлсэн Нөлөөлөл 2020-2021" судалгаагаар КОВИД-19 дэлхийд төдийгүй Монгол Улсын аялал жуулчлалын салбарт ялангуяа зочид буудал, нийтийн хоолны салбарт хамгийн ихээр буюу 83%-иар нөлөөлсөн байна⁷.

2.1. Хоол хүнс, ундаа, сав баглаа боодлын нийлүүлэлт

Европын холбооны Свич Эйшиа (SWITCH ASIA) хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсын нүүрстөрөгчийн хийн ялгарлыг бууруулах, нөөцийн хэмнэлттэй ТЭЗ-т шилжих, улмаар ядуурлыг бууруулахад хувь нэмэр оруулах зорилготой "Эдийн засгийн ногоон шилжилт" төслийн хүрээнд хийгдсэн "Хөдөө аж ахуйн хүнс, ус ундаа үйлдвэрлэлийн салбарын нарийвчилсан судалгаа"-аар хоол хүнс, ус ундаа үйлдвэрлэлийн салбарын өнөөгийн нөхцөл байдлыг харуулбал;

Хоол хүнс, ус ундаа үйлдвэрлэл: Монгол Улсын хэмжээнд ундааны 30, савласан усны 90, шүүсний 44 үйлдвэр, давхардсан тоогоор нийт 162 үйлдвэр үйл ажиллагаа явуулж байна. Хоол хүнс, ус ундаа үйлдвэрлэгчдийн 61% нь хоол, хүнсний үйлдвэрлэл, 25% нь ус ундааны үйлдвэрлэл, 7% хоолны үйлдвэрлэл, үйлчилгээ эзэлж байгаа ба 95% нь дотоодын хөрөнгө оруулалттай болно. Уг дэд салбарын ялгаа нь 70% нь зохион байгуулалтын хувьд ХХК хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулдаг юм. Тэдгээрийн 37% нь 100 мкв хүртэл, 23% нь 101-200 мкв, 16% нь 201-500 мкв, 10% нь 501-1000 мкв, 15% нь 1001-с дээш мкв талбайд үйлдвэрлэл явуулдаг. Үйл ажиллагаа явуулж буй хугацааны тархалт мөн хэвийн боловч бичил (55%) бизнесээс гадна 11-50 ажилтантай жижиг (36%), дунд (9%) байгууллагууд тал хувийг бүрдүүлдэг юм. Хэмжээний хувьд томорч байгаа тул мөн жилийн дундаж

² Аялал жуулчлалын салбарын мэдээ. (2021) Холбоос: <https://ikon.mn/n/2cf1>

³ ХХААХҮЯ. Аялал жуулчлалын салбарын мэдээ. (2020) Холбоос: <http://mofa.gov.mn>

⁴ JICA. Монгол дахь тогтвортой аялал жуулчлалын хөгжил-судалгааны тайлан. (2021) Холбоос: <https://openjicareport.jica.go.jp/pdf/12366928.pdf>

⁵ УСХ. ЖДҮ эдийн засгийн үйл ажиллагааны ангиллаар. (2021) Холбоос: https://www2.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_BR_01V2&T1_select=all=0&T1SingleSelect=4_8_3&YearY_select=all=0&YearYSingleSelect=2021&viewtype=table

⁶ БОАЖЯ. Аялал жуулчлалыг сэргээх стратеги төлөвлөгөө Инбаунд аялал жуулчлал 2022-2024

⁷ БОАЖЯ. Аялал жуулчлалыг сэргээх стратеги төлөвлөгөө Инбаунд аялал жуулчлал 2022-2024

орлогын хувьд 54% нь 99 сая, 18% нь 100-299 сая, 15% нь 1 тэрбум хүртэл, 9% нь 2.5 хүртэл тэрбум төгрөгийн орлоготой байна.

Түүхий эд материалаа 38% дотоодын үйлдвэрлэгч, байгууллагуудаас, 24% нь бөөний болон жижиглэнгийн худалдаачдаас, 18% нь импортлогч байгууллагуудаас, 12% өөрсдөө импортолж оруулж ирдэг, үлдсэн 8% нь өөрсдөө боловсруулдаг. Хүнс, ус ундаа үйлдвэрлэлийн процесс харилцан адилгүй байдаг ба тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, цэвэрлэгээг тогтмол хийдэг. Бэлэн бүтээгдэхүүнээс 38% нь гялгар уут, 18% дахин боловсруулсан хуванцар сав, 18% дахин боловсруулсан цаасан материал, 10% нь шил, 6% даавуун уутанд хадгалдаг. Бүтээгдэхүүний 50% нь Улаанбаатар хотод, 49% нь орон нутагтаа борлуулдаг, 1% нь экспортолдог ба жижиглэнгийн худалдаачдад 33%, бөөний худалдаачдад 24%, 26% нь шууд эцсийн хэрэглэгчдэд, 8% нь хоолны үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдэд, 5% нь зуучлагчдад, 2% нь боловсруулах үйлдвэрт, 2% нь хоршоо нөхөрлөлд борлуулдаг байна. Үйлдвэрлэлийн хог хаягдлаа 10% бордоо хийдэг, 9% шатааж устгадаг, 2% газар дүүргэлтэд ашигладаг, 19% малын тэжээл болгодог, 16% борлуулдаг, боловсруулахгүй хаядаг 37% байна.

Жижиглэнгийн худалдаа, үйлчилгээ: Жижиглэнгийн худалдаа үйлчилгээ, хоолны үйлдвэрлэл, тээвэрлэлт, агуулахын газруудын хувьд Улаанбаатар хотын хэмжээнд хүнсний жижиглэнгийн худалдаа, үйлчилгээний нийт 6,266 газар байна. Мөн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт нийтдээ 8,320 орчим аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байгаагийн 47% нь аймаг орон нутагт, 53% нь нийслэл хотод ажиллаж байна. Үйлчилгээний төрлөөр нь авч үзвэл ресторан зочид буудлын хоолны үйлдвэрлэл (1,570), баар караоке (1,331), цэцэрлэг сургууль (1,600) болон төрийн үйлчилгээний байгууллагуудын хоолны газрууд дийлэнх хувийг эзэлж байна. Энэ салбарт нийт 40,000 гаруй ажилтан ажилладаг. Хоолны газрын нийт суудлын тоо 600-650 мянга байна. Жижиглэнгийн худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн 47% нь жижиглэнгийн худалдаа, 37% нь хоол үйлдвэрлэл үйлчилгээ, 7% нь агуулах, 8% нь тээвэрлэлтийн үйлчилгээ эрхэлж байна. Тэдгээрийн 85% нь бичил, 11% нь жижиг, 4% нь дунд болон том байгууллага бүрдүүлж байна. Тэдгээрийн 11% нь 10 мкв хүртэл, 30% нь 10-30 мкв, 16% нь 31-50 мкв, 21% нь 51-100 мкв, 12% нь 101-200 мкв, 6% нь 201-500 мкв, 4% нь 501-с дээш мкв талбайд үйл ажиллагаа явуулдаг. БЖДБЭ-д ихэвчлэн дотоодын хөрөнгө оруулалттай, 67% нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 29% нь ХХК бөгөөд үйл ажиллагаа явуулж буй хугацааны тархалт жигд, дийлэнх нь 1-10 ажилтантай, 99 сая төгрөгийн орлоготой байна. Тэдгээр хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хувьд усны хэмнэлт 85%, борооны ус, саарал ус ашиглалт 17%, эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмжийн ашиглалт 39%, олон дахин ашиглах боломжтой материал ашиглалт 35%, дахин боловсруулагдсан материал ашиглалт 38% байна. Тоног төхөөрөмжийн тогтмол цэвэрлэгээ 82%, тоног төхөөрөмжийн тогтмол засвар үйлчилгээ 83%. Бэлэн бүтээгдэхүүнээ 34% нь зориулалтын агуулахад, 46% нь хөргөгч, хөлдөөгчид, 14% нь хөргүүртэй машинд хадгалдаг. Хэрэглэгчдийн 69% шууд эцсийн хэрэглэгчдэд, 21% байгууллагын хэрэглэгчдэд, 8% нь төрийн байгууллага бүрдүүлж байна.

Сав баглаа боодлын үйлдвэрлэл: Монгол Улсын хэмжээнд сав баглаа боодлын чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй 57 гаруй үйлдвэрт 3,000 орчим хүн ажилладаг бөгөөд жилд 150 орчим тэрбум төгрөгийн бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг. Энэ нь дотоодын үйлдвэрлэлийн нийт зах зээлийн 60 орчим хувийг эзэлдэг байна. Монгол улсад жилдээ 520 тэрбум төгрөгийн сав баглаа боодлын хэрэгцээ шаардлагатай гэсэн судалгаа тооцоо байдаг. Гэвч сав баглаа боодлын хэрэгцээний ойролцоогоор 70 хувийг импортоор, 30 хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангаж байна⁸. Өөрөөр хэлбэл, сав баглаа боодлын дотоодын үйлдвэрлэл дотоодын нийт эрэлт хэрэгцээг хангаж чадахгүй байгаагаас гадна, хүлэмжийн хийн ялгарал, хог хаягдал зэрэг байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөгөөрөө ихээхэн анхаарал татаж буй салбаруудын нэг юм. Тиймээс сав баглаа боодлын

⁸ ХХААХҮЯ. (2020) Сав баглаа боодлын үйлдвэрлэл. Холбоос: <https://www.mofa.gov.mn/home>

Үйлдвэрлэл нь бүтээгдэхүүнийг гадаад орчноос хамгаалах уламжлалт шинж чанараас илүүтэй бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийг уртасгах, дахин боловсруулах, брэнд хөгжүүлэх, нэмүү өртөг бий болгох, зардлыг бууруулах замаар дотоодын эрэлт хэрэгцээг хангах хүчин чадлыг нэмэгдүүлэхээс гадна байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг нь бууруулах зэрэг шинэ чиг хандлагаар хөгжих хэрэгцээ шаардлага тулгарч байна.

Зорилтот салбар дах эмэгтэйчүүд манлайлж буй БЖДБЭ-дийн хувьд:

Үндэсний статистикийн хорооны 2021 оны аж ахуйн нэгжийн тооллогын урьдчилсан дүнгээр Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй нийт аж ахуйн нэгжийн 38% нь эмэгтэй захиралтай байна. Харин жижиг, дунд үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа эрхэлж буй бизнес эрхлэгчдийн 60 гаруй хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаа юм. Гэвч эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин сүүлийн жилүүдэд буурах хандлагатай байгаа бөгөөд энэ оны эхний улирлын байдлаар 50.4 хувьтай байхад эрэгтэйчүүдийнх 66.5 хувьтай байна. Бизнесийн гол салбараар харьцуулан үзвэл, хөдөө аж ахуйн салбарт бизнес эрхэлж буй эмэгтэйчүүд (52%) түлхүү хамтарсан бизнес эрхэлж байгаа бол, жижиглэн худалдаа (85%), үйлдвэрлэл (80%), үйлчилгээний (80%) салбарт ажиллаж буй эмэгтэйчүүд бизнесээ дангаараа эзэмшиж байна. Зочид буудал, зоогийн газар боловсруулах салбарт үйл ажиллагаа явуулж буй БЖДБЭ-дийн хувьд 41,6% нь эмэгтэй захиралтай буюу 58,4% нь эрэгтэй захиралтай 1:1,4 харьцаатай байна⁹.

2.2. Хоол хүнс, ундаа, сав баглаа боодлын эрэлт

Монгол Улс жилд ойролцоогоор 500,000 гаруй жуулчид дэлхийн өнцөг бүрээс ирдэг гэсэн судалгаа бий¹⁰. Дэлхийн Тогтвортой Аялал Жуулчлалын Зөвлөлийн мэдээлснээр Монголын аялал жуулчлалын салбар ойрын жилүүдэд аажмаар сэргэж, 2021-2030 он хүртэл жилийн 5.5%-ийн өсөлттэй байх төлөвтэй байна¹¹. Иймээс зах зээлийн цар хүрээний хувьд аялал жуулчлалын салбар дахь хоол хүнс, ундаа сав баглаа боодлын салбар ирэх жилүүдэд өсөх хандлагатай.

Эрэлт өсөх хандлагатай байгаа боловч, дэлхий даяар хүний хэрэгцээнд зориулан үйлдвэрлэсэн хүнсний бүтээгдэхүүний гуравны нэг орчим нь (жилд ойролцоогоор 1.3 тэрбум тонн хаягдаж байхад 1 тэрбум орчим хүн өлсгөлөнд нэрвэгдэж байдаг байна. Хүнсний сүлжээ нь зөвхөн нийгэм, ёс суртахууны асуудал бус байгаль орчныг хамгаалахад чухал ач холбогдолтой. Хүнсний үйлдвэрлэл, түгээлт, хадгалалтад байгалийн асар их нөөцийг ашигладаг ба хүнсний хог хаягдал дангаараа хүлэмжийн хийн ялгарлын 8 орчим хувийг бүрдүүлдэг зэргээр уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлсөөр байна. Иймд хүнсний хог хаягдлын тогтвортой менежментийн асуудал нь нийгэм, байгаль орчин, эдийн засгийн аль ч үүднээс зайлшгүй анхаарах зүйл юм. Европын Байгаль Орчны Агентлагийн мэдээлснээр хүнсний хог хаягдлын гол эх үүсвэр нь айл өрх (42%), хоол боловсруулах болон үйлдвэрлэлийн аж ахуйн нэгжүүд (39%), зочид буудал, ресторан (14%), эцэст нь бөөний болон жижиглэнгийн худалдаачид, хүнсний дэлгүүр, супермаркет, томоохон дэлгүүрүүд (5%) байна¹². Тиймээс зөвхөн эрэлтийг хангах зорилгоор үйлдвэрлэх биш, үр ашигтай, байгаль орчинд ээлтэй, нөөцийн үр ашигтай, хог хаягдалгүй багатай, дахин боловсруулах тогтолцоотой үйлдвэрлэл эрхлэх хэрэгцээ шаардлага гарч байна.

⁹ ҮСХ. Эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжүүд. (2021) Холбоос: <https://www2.1212.mn/>

¹⁰ БОАЖЯ. Аялал жуулчлалыг сэргээх стратеги төлөвлөгөө Инбаунд аялал жуулчлал 2022-2024

¹¹ БОАЖЯ. Аялал жуулчлалыг сэргээх стратеги төлөвлөгөө Инбаунд аялал жуулчлал 2022-2024

¹² FAO. Европын холбооны хүнсний хог хаягдлын судалгаа (2022) Холбоос: <https://www.eea.europa.eu/media/infographics/wasting-food-1>

3. Сорилт ба боломжууд

Монгол Улсын аялал жуулчлалын салбарын үйлдвэрлэлийн хувьд КОВИД-19 цар тахал бол хамгийн том сорилтуудын нэг байсан төдийгүй үүний нөлөө, хор уршиг үргэлжилж байна. МҮХАҮТ-иас хийсэн судалгааны үр дүнгээс үзвэл цар тахлын үед тур оператор байгууллагуудын орлого 80%-иар, зочид буудлын орлого 63%- иар, жуулчны баазуудын орлого 84%-иар, ресторануудын орлого 51%-иар тус тус буурсан байна. Үйлчилгээ эрхлэх ААНБ-д олон төрлийн (үл хөдлөх хөрөнгө, НДШ, ААНОАТ, газрын төлбөр гм) татварын өрийн дарамтад орсон байна. Өөрөөр хэлбэл, БЖДБЭ-дийн хувьд санхүүгийн хямралд орсон тул үйл ажиллагаагаа сэргээн явуулахад хүндрэлтэй байна.

Хүснэгт 2. Аялал жуулчлалын салбарын БЭ-дэд цар тахлын үзүүлж буй нөлөө судалгаа¹³

	Ресторан	Зочид буудал	Жуулчны бааз	Тур оператор
ҮЙЛ АЖИЛЛАГАА, БИЗНЕС ДЭХ НӨЛӨӨ				
Үйл ажиллагаа явуулж байгаа эсэх	- Үйл ажиллагаа явуулж байгаа (100%)	- Үйл ажиллагаа явуулж байгаа (89.2%) - Үйл ажиллагаа түр зогссон, дахин эхлэхээр төлөвлөж байгаа (5.4%)	- Үйл ажиллагаа түр зогссон, дахин эхлэхээр төлөвлөж байгаа (68.9%) - Үйл ажиллагаа явуулж байгаа (27.9%)	
Орлого, Ажлын байрны тооны өөрчлөлт	- Орлого: 51% буурсан - Ажлын байрны тоо: 50% буурсан	- Орлого: 63% буурсан - Ажлын байрны тоо: 25% буурсан	- Орлого: 84% буурсан - Ажлын байрны тоо: 68% буурсан	- Орлого: 80% буурсан - Ажлын байрны тоо: 78% буурсан
Бизнест үзүүлсэн нөлөө	- Бараа, материал, түүхий эдийн үнэ өссөн (75%) - Үйлчилгээний эрэлт буурсан (37.5%) - Зээл татвар түрээсийн төлбөрийн өр үүссэн (37.5%)	- Үйлчилгээний эрэлт буурсан (70.3%) - Зээл, татвар, түрээсийн төлбөрийн өр үүссэн (51.4%) - Бараа, материал, түүхий эдийн үнэ өссөн (51.4%)	- Үйлчилгээний эрэлт буурсан (77%) - Орлого ихээр буурсан буюу орлогогүй болсон (55.7%) - Бараа, материал, түүхий эдийн үнэ өссөн, бэлэн мөнгөний хомстолд орсон (31.1%)	- Хил хаагдаж жуулчин авч чадахгүй болсон (89%) - Орлого ихээр буурсан буюу орлогогүй болсон (68.3%) - Санхүүгийн эх үүсвэргүй болсон (31.7%)
Засгийн газрын дэмжлэгийн хүртээмж	- Ус цахилгаан дулааны төлбөр хөнгөлөлт, чөлөөлөлт (100%) - НДШ-ийн хөнгөлөлт (87.5%) - Ажлын байраа хадгалсан ААН-н ажилтанд дэмжлэг үзүүлэх/ 3 сарын хугацаанд сар бүр 200 мян.төг олгох/ (75%)	- ЗГ-ын 3 хувийн зээл (67.6%) - НДШ-ийн хөнгөлөлт (62.2%) - Ажлын байраа хадгалсан ААН-н ажилтанд дэмжлэг үзүүлэх/ 3 сарын хугацаанд сар бүр 200 мян.төг олгох/ (40.5%)	- Ус цахилгаан дулааны төлбөр хөнгөлөлт, чөлөөлөлт (45.9%) - НДШ-ийн хөнгөлөлт (37.7%) - Ямар нэг дэмжлэг аваагүй (31.1%)	- Ус цахилгаан дулааны төлбөр хөнгөлөлт, чөлөөлөлт (50%) - Ямар нэг дэмжлэг аваагүй (31.7%) - Ажлын байраа хадгалсан ААН-н ажилтанд дэмжлэг үзүүлэх/ 3 сарын хугацаанд сар бүр 200 мян.төг олгох/ (31.7%)
БИЗНЕСЭЭ СЭРГЭЭХЭД ТУЛГАРЧ БҮЙ ХҮНДРЭЛ, ШААРДАГДАХ ДЭМЖЛЭГ				

¹³ БОАЖЯ. Аялал Жуулчлалыг Сэргээх Стратеги Төлөвлөгөө Инбаунд Аялал Жуулчлал 2022-2024

2022 онд жуулчин хүлээж авахад тулгарч буй хүндрэл	- Түүхий эд, бараа материалын үнийн өсөлт (75%) - Хуримтлагдсан татварын өр төлөлт (50%) - Үл хөдлөх хөрөнгийн татвар төлөлт (37.5%)	- Хуримтлагдсан татварын өр төлөлт (51.4%) - НДШ, ХАОАХ-ын хуримтлагдсан өр (51.4%) - Түүхий эд, бараа материалын үнийн өсөлт (43.2%) - Үл хөдлөх хөрөнгийн татвар төлөлт (35.1)	- Аялал жуулчлалын салбарын онцлогийг харгалзаж үзээгүй бодлого, хуулийн зохицуулалтууд (50.8%) - Үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдох үнэлгээ, зөвшөөрлийг сунгах, авахтай холбогдох ойлгомжгүй байдал (39.3%) - Газрын татвар төлөлт (34.4%)	- Гадаад нислэгийн хуваарь тодорхойгүй (64.6%) - Гадаад маркетинг сурталчилгаа хийх санхүүгийн эх үүсвэр (45.1%) - Эргэлтийн хөрөнгийн эх үүсвэр буюу зээл (43.9%)
Цаашид шаардагдах дэмжлэг	- Ус, цахилгаан, дулааны төлбөр хөнгөлөх чөлөөлөх арга хэмжээг хойшлуулах (75%) - ААН-ийн албан татвар, НДШ-ийг хойшлуулах, хөнгөлөх (50%) - Зээлийн төлбөр, хүү төлөх хугацааг хойшлуулах (37.5%)	- ААН-ийн албан татвар, НДШ-ийг хойшлуулах, хөнгөлөх (51.4%) - Ус, цахилгаан, дулааны төлбөр хөнгөлөх чөлөөлөх арга хэмжээг хойшлуулах (45.9%) - Үйл ажиллагааг тогтвортой, тасралтгүй явуулах нөхцөлийг хангах, хөл хорио тогтоохгүй байх (37.8%)	- Аялал жуулчлалын салбарын гол оролцогч талуудад төрөөс хөнгөлөлттэй зээл олгох (47.5%) - ААН-ийн албан татвар, НДШ-ийг хойшлуулах, хөнгөлөх (45.9%) - Төрийн үйлчилгээний хүнд суртлыг бууруулах (29.5%)	- 2022 оны гадаад, дотоод нислэгийн хуваарийг яаралтай баталж зарлах (61.7%) - Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг 2022 он дуустал олгох (61.7%) - НДШ-ээс хөнгөлөх, чөлөөлөх, төлөх хугацааг хойшлуулах (59.3%)
Хэрэгцээт санхүүжилтийн зарцуулалт	- Салбартаа үйл ажиллагаагаа өргөжүүлэх (75%) - Шинэ ажлын байр бий болгох (37.5%) - Ажилтны цалин хөлсөнд зарцуулах (25%)	- Ажилтны цалин хөлсөнд зарцуулах (48.6%) - Салбартаа үйл ажиллагаагаа өргөжүүлэх (45.9%) - Шинэ ажлын байр бий болгох (29.7%)	- Эргэлтийн хөрөнгө нэмэгдүүлэх (52.5%) - Салбартаа үйл ажиллагаагаа өргөжүүлэх (52.5%) - Шинэ ажлын байр бий болгох (34.4%)	- Гадаад зах зээлд сурталчилгаа шинээр хийх (47.6%) - Ажлын байрыг өргөтгөж, нэмэх (39%) - Салбартаа үйл ажиллагаагаа өргөжүүлэх (22%)

Олон улсын жуулчдын тоо, эрэлт буурснаас шалтгаалж жуулчин хүлээн авагч орнуудын өрсөлдөөн нэмэгдсэн. Түүнчлэн, аялал жуулчлалын салбарын хоол хүнс, ундаа, сав баглаа боодлын үйлдвэрлэлийн дотоодын зах зээлийн /эрэлт нийлүүлэлтийн/ хувьд, салбарын өрсөлдөөний нөхцөл байдлыг харвал;

Эрэлт талаасаа КОВИД-19-ын дараах шинэ сэргэлттэй холбоотой дотоодын болон гадаадын жуулчдын тоо өсөх, уур амьсгалын өөрчлөлт болон хүний зохисгүй үйл ажиллагааны улмаас аялал жуулчлалын бүсийн байгалийн нөхцөл, нөөц доройтож байна. Үүнтэй холбоотой жуулчдын буюу хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлага өөрчлөгдөж, хэрэглэгчид хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө багатай

төдийгүй байгаль орчинд ээлтэй, сав баглаа боодлын хувьд чанар шаардлага нь өндөр бүтээгдэхүүн үйлчилгээг чухалчилдаг хандлага бий болж байна¹⁴.

Нийлүүлэлт талаасаа бүтээгдэхүүний нэр төрөл цөөн, дотоодын бүтээгдэхүүн хоорондын өрсөлдөөн бага, аж ахуйн нэгжүүд техник тоног төхөөрөмжийн хүчин чадал сул, стандарт мөрдөлт сул, хэрэглэгчийн хэрэгцээнд тааруулж өөрчлөлт хийх уян хатан чадвар бага, өөрсдийн тогтсон борлуулалтын суваггүй, бөөний борлуулагч нарт нийлүүлдэг, үйлдвэрлэлийн тоо хэмжээ бага, өргөжилтийн хэмнэлт хийх боломж бүрдээгүй зэргээс харвал өрсөлдөх чадварын сул түвшинд байна. БЖДБ-ийн өнөөгийн өрсөлдөх чадвар нь үйл ажиллагаагаа өргөжүүлэх, зах зээлээ тэлэх, цаашлаад ногоон эдийн засгийн туршлагуудыг нэвтрүүлэхэд хязгаарлагдмал байна.

Хүснэгт 3. БЖДБЭ-д дэд салбарт нөлөөлж буй дотоод хүчин зүйлс

БЖДБЭ-д дэд салбарт нөлөөлж буй гадаад хүчин зүйлс	БЖДБЭ-д дэд салбарт нөлөөлж буй дотоод хүчин зүйлс
Цар тахлын нөхцөл байдал	Улирлын хамаарал өндөр
Эдийн засгийн хямрал	Жуулчны үйлчилгээний дэд бүтцийн (эрүүл, аюулгүй үйлчилгээний, үйлдвэрлэл эрхлэлтийн) стандарт мөрдөлт муу Хязгаарлагдмал дэд бүтэц: Монголын аялал жуулчлалын дэд бүтэц шинээр хөгжиж байгаа бөгөөд энэ нь алслагдсан бүс нутагт хоол хүнс, ундааны бизнес эрхлэхэд хүндрэл учруулж болзошгүй юм. Энэ нь сав баглаа боодлын материал болон бусад нөөцийн нийлүүлэлтэд хүндрүүл учруулж байна.
Зээл авах боломж бололцоо, төрөөс олгох санхүүгийн дэмжлэг байхгүй	Санхүүгийн хүндрэлээс шалтгаалан өргөжин тэлэх боломж муу, үйлдвэрлэлийн хүчин чадал сул, тоног төхөөрөмжийн хангамж муу
Зах зээлийн өрсөлдөөн нэмэгдсэн	Хэрэглэгчдийн стандарт, шаардлагыг хангасан өрсөлдөхүйц бүтээгдэхүүн хөгжүүлэх мэдлэг мэдээлэл, чадвар, туршлага сул Учир нь сүүлийн жилүүдэд жуулчид буюу хэрэглэгчид хариуцлагатай хэрэглээ болон тогтвортой аялал жуулчлалын практикийг ихээхэн дэмжин чухалчилдаг болсон.
Зах зээлийн нийлүүлэлтийн сүлжээ	Өөрсдийн тогтсон борлуулалтын суваггүй, маркетинг, идэвхжүүлэлт сул
Байгаль орчны доройтол	Байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл эрхлэлтийн мэдлэг мэдээлэл, туршлага сул
Тойрог эдийн засгийн ойлголт, туршлага сул / хангалтгүй	Хог хаягдлын менежмент байхгүй - Аялал жуулчлалын салбар нь хүнсний болон сав баглаа боодлын хог хаягдал зэрэг ихээхэн хэмжээний хог хаягдал үүсгэдэг. Монгол Улсад хог хаягдлын менежментийн дэд бүтэц шинэ хөгжиж байгаа тул бизнес эрхлэгчдэд хог хаягдлын менежментийн талаар мэдлэг мэдээлэл сул.
Инновац, дижитал хөгжил	Байгууллагын дотоод чадавх, мэргэжлийн хүний нөөцийн хомсдол,

Европын холбооны Свич Эйшиа хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсын нүүрстөрөгчийн хийн ялгарлыг бууруулах, нөөцийн хэмнэлттэй ТЭЗ-т шилжих, улмаар ядуурлыг бууруулахад хувь нэмэр оруулах зорилготой “Эдийн засгийн ногоон шилжилт” төслийн хүрээнд хийгдсэн “Хөдөө аж ахуйн хүнс, ус ундаа үйлдвэрлэлийн салбарын нарийвчилсан судалгаа”-ны үр дүнд БЖДБ-н хувьд санхүүжилтийн хэрэгцээ шаардлага, сургалт, зөвлөх үйлчилгээ, засгийн газрын дэмжлэг нэн тэргүүнд шаардлагатай гэж гарсан байна. Санхүүжилтэд тулгамдаж буй гол асуудал нь нэг талаас санхүүжилтийн эх үүсвэр хязгаарлагдмал, барьцаа хөрөнгө, зээлийн хүү зэрэг санхүүжилт авахад тулгардаг хүндрэлүүд нь

¹⁴ БОАЖЯ. Аялал Жуулчлалыг Сэргээх Стратеги Төлөвлөгөө Инбаунд Аялал Жуулчлал 2022-2024


Зураг 3. Салбарын хувьд тулгамдаж буй асуудлууд



“Хөдөө аж ахуйн хүнс, ус ундаа үйлдвэрлэлийн салбарын нарийвчилсан судалгаа”-аар БЖДБЭ нарын ТЭЗ-ийн зарчмуудын хэрэгжилт хангалтгүй, ихэнх нь ТЭЗ-ийн ойлголтын талаар мэдлэг мэдээлэл дутуу гэж гарсан бөгөөд үүний шалтгаан үр дагаврыг дараах байдлаар шинжлэн харуулжээ.

Зураг 4 Шалтгаан, үр дагаврын диаграм¹⁶

¹⁶ Эдийн Засгийн Ногоон Шилжилт Төсөл. (2022) Хөдөө аж ахуйн хүнс, ус ундаа үйлдвэрлэлийн салбарын нарийвчилсан судалгаа




Үүнээс харахад, аялал жуулчлалын салбарын үйлдвэрлэлийн онцлогт тохирсон урт хугацааны хөнгөлөлттэй зээл олгох болон ТЭЗ-ийг ойлголтыг нэвтрүүлэх замаар аялал жуулчлалын дэд бүтцийг нутгийн иргэд, жуулчдын эрэлт хэрэгцээнд нийцүүлэн байгаль орчинд хохиролгүйгээр хөгжүүлэх хэрэгцээ шаардлага байгаа бөгөөд Монгол Улсын аялал жуулчлалын салбарын зах зээлийн хувьд цаашид өсөх, өргөжин тэлэх хандлагатай байгаа тул олон талын хамтын ажиллагаа, төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн хүрээнд эдгээр асуудлыг шийдэх боломж бас хангалттай байна гэж харагдаж байна.

4. Бизнес эрхлэгчдийн ТЭЗ-ийн талаарх хэрэгцээ шаардлага

4.1. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл


Төслийн зорилтот бүлэгтэй уялдуулан судалгаанд хамруулсан бизнес эрхлэгчдийг сонгохдоо эмэгтэй эзэнтэй болон эмэгтэй удирдлагатай байх гэсэн ерөнхий шаардлагыг тавьсан. Тиймээс судалгаанд хамрагдсан бүхий л бизнесүүд энэ шаардлагыг бүрэн хангасан. Харин тухайн бизнесийг төлөөлж судалгаанд хамрагдсан оролцогчдын 80.5% нь эмэгтэй, үлдсэн 19.5% нь эрэгтэй байна. Тэдний амьдарч буй газар болон бизнес эрхэлж буй байршлын хувьд бага зэрэг ялгаатай байна.

Зураг 5. Судалгаанд оролцогчдын амьдардаг газар болон бизнес эрхэлдэг газар




Судалгаанд 18-75 насны 400 хүн хамрагдсанаас ихэнх нь 37-39 насныхан хамгийн ихээр хамрагдаж, 61.5% нь буюу ихэнх нь дээд боловсролтой байна.

Зураг 6. Насны бүтэц, %



Зураг 7. Боловсролын түвшин, %



Судалгаагаар оролцогчдын ТЭЗ-ийн талаарх мэдлэг, хандлагыг тодруулж, түүнд тулгуурлан мэдлэгийг дээшлүүлэх хэрэгцээ, шаардлагыг судалж буй тул боловсролын түвшнээс хамаарсан мэдлэгийн ялгаа болон хэрэгцээ бий эсэхийг шалгах нэг үзүүлэлт болох юм.

4.2. Бизнесийн нийтлэг үйл ажиллагаа

Энэ хэсэгт зорилтот бизнесийн салбаруудын үйл ажиллагааны чиглэл, бизнесийн борлуулалтын орлого, ажилтны тоо зэрэг бизнесийн зарим ерөнхий үзүүлэлтийг авч үзсэн.

Нийт судалгаанд хамрагдсан бизнесийн 92% нь албан ёсны бүртгэлтэй бизнес байна. Эдгээрийн 90% нь хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэрээр, 1.5% нь хоршоо, нөхөрлөл хэлбэрээр, 0.8% нь ТББ хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байна. Үлдсэн 8% нь гэр бүлийн болон хувийн бизнесүүд байгаа ба бизнесээ бүртгүүлээгүй шалтгаан нь түрээсэлж ажиллуулдаг, үйл ажиллагаа эхлээд удаагүй, зөвшөөрөлгүй, энэ талаар сайн мэдэхгүй зэрэг шалтгааныг дурджээ.

Судалгаанд оролцогчдын 68% нь захирал, эзэн, гэр бүлийн хамтран бизнес эрхлэгч зэрэг өөрсдийн бизнесийн үйл ажиллагааг бүхэлд нь тодорхойлж, мэдээлэл өгөх боломжтой удирдах албан тушаалтнууд байна. Үүний дараа менежерүүд мөн түлхүү хамрагджээ (Зураг 8).


Судалгаанд хамрагдах байгууллагуудыг бид дараах зорилтот салбарын хүрээнд тодорхойлсон түүврийн дагуу мэдээлэл цуглуулсан (Зураг 9. Үйл ажиллагааны чиглэл, %Зураг 9). Зорилтот салбаруудын түүврийг төлөвлөхдөө ҮСХ-ны 2022 оны Бизнес регистрийн санд бүртгэгдсэн зорилтот салбарын статистикийг баримталсан. Бизнес регистрийн санд бүртгэгдсэн байр, сууц болон хоол, хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа 2.6%, хүнс болон ундааны үйлдвэрлэл 2.3% буюу ойролцоо тоотой байгаа нь түүвэрт ижил түвшинд хамрагдсан байна. Бизнес регистрийн санд бүртгэлтэй жижиглэн худалдааны салбар 11%-ийг эзэлж байгаа боловч хүнсний худалдааны салбар үүнээс хэдэн хувийг нь эзэлж байгаа нь тодорхойгүй тул дээрх хоёр салбарын үйл ажиллагаатай харьцуулахад ач холбогдол багатай гэж үзэн түүвэрт арай бага хэмжээнд хамруулсан.

Үйл ажиллагааны чиглэлээр харвал 1/3 нь аялал жуулчлалын бааз, зочид буудал зэрэг байраар хангах үйлчилгээ үзүүлэгчид, 1/3 нь ресторан, хоолны газар зэрэг хоол үйлдвэрлэл, үйлчилгээ үзүүлэгчид, үлдсэн 1/3 нь бусад зорилтот салбарынхан байна.

Зураг 8. Судалгаанд оролцогчдын албан тушаал, %



Зураг 9. Үйл ажиллагааны чиглэл, %




Эдгээр бизнесүүдийн 97.3% нь дотоод хөрөнгө оруулалттай, үлдсэн хэсэг нь гадаадын болон хамтарсан хөрөнгө оруулалттай бизнесүүд байв. Гадаадын болон хамтарсан хөрөнгө оруулалттай салбарынхан гол төлөв хоол үйлдвэрлэлийн салбарынхан болон байраар хангах үйлчилгээний бизнесийнхэн байна.


Бизнесийн үйл ажиллагаа эрхэлсэн жилээр ангилбал жигд түүвэртэй байна (Зураг 10). Судалгаанд хамрагдсан бизнесүүдийн 44.3% нь 5 хүртэлх жил үйл ажиллагаагаа явуулж буй харьцангуй шинэ бизнесүүд байгаа бол 37.8% нь 10-аас дээш жил үйл ажиллагаа явуулж буй бизнесүүд байна.

Төслийн үйл ажиллагааны зорилго нь ТЭЗ-ийн чиглэлд жижиг, дунд бизнес эрхлэгчдийг чадавхжуулах тул бид 250-аас дээш ажилтантай том бизнесүүдийг хамруулаагүй. Түүвэрт хамрагдсан ихэнх бизнесүүд 10 хүртэлх ажилтантай бичил бизнес эрхлэгчид байна (Зураг 11). Дунд хэмжээний буюу 50-аас дээш ажилтантай бизнесүүд гол төлөв хүнсний үйлдвэрлэл, ундааны үйлдвэрлэл, зочлох үйлчилгээний салбар, сав баглаа боодлын салбарынхан байна.

Зураг 10. Бизнесийн үйл ажиллагаа эрхэлсэн жил, %



Зураг 11. Ажилтны тоо, %



Судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгчдийн 80.3% нь тогтмол үйл ажиллагаа эрхэлдэг, 19.3% нь улирлын шинж чанартай үйл ажиллагаа эрхэлдэг, 0.5% нь өөрийн хүссэн үедээ ажиллаж орлого олдог гэжээ. Улирлын чанартай үйл ажиллагаа эрхэлдэг бизнесүүдэд байраар хангах үйлчилгээ болон хоол үйлдвэрлэлийн салбарынхан хамаарч байгаа бол хүссэн үедээ үйл ажиллагаагаа эрхэлдэг бизнест хүнсний үйлдвэрлэл болон хоол, ус ундаагаар үйлчилгээ үзүүлэгчид хариулсан байна.

Нийт бизнес эрхлэгчдийн 20% орчим нь улирлаас хамаарсан тогтмол биш орлоготой тул бизнесийн эргэлтийн хөрөнгийг жилээр тооцон харуулав (Хүснэгт 4). Улирлын чанартай бизнес эрхлэгчдийн жилийн эргэлтийн хөрөнгө ихэвчлэн 500 сая хүртэлх байна.

Хүснэгт 4. Бизнесийн жилийн эргэлтийн хөрөнгө 2022 он

Жилийн эргэлтийн хөрөнгө	Нийт	Тогтмол	Улирлын чанартай
50 сая ₮ хүртэл	50.7%	73.4%	25.6%
99 сая ₮ хүртэл	12.8%	84.3%	15.7%
100-300 сая ₮	19.5%	85.9%	14.1%
301 сая -500 сая ₮	8.0%	84.4%	15.6%
501 сая -1 тэр бум ₮	4.0%	100.0%	0.0%
1 тэрбумаас дээш	5.0%	95.0%	5.0%

Үйл ажиллагааны төрлөөр харьцуулж харвал Хүнсний үйлдвэрлэлийн чиглэлийн жилийн эргэлтийн хөрөнгө 500 саяас дээш, хоол үйлдвэрлэлийн салбарынхан 100 сая хүртэл, хүнсний дэлгүүр 100-500 сая хүртэл, байраар хангах үйлчилгээ үзүүлдэг бизнес эрхлэгчдийн жилийн эргэлтийн хөрөнгө янз бүр байна.

Тоон судалгаанд хамрагдсан бизнесийн төлөөллийг ҮСХ-ны 2022 оны Бизнес регистрийн санд бүртгэлтэй ААН-ийн үйл ажиллагааны салбар, ажиллагчдын тоо, хариуцлагын болон өмчийн хэлбэрээр харьцуулан харвал ойролцоо харьцаатай түүврийг бүрдүүлсэн нь төлөөлөх чадварыг илтгэсэн үзүүлэлт юм.

4.3. Тойрог эдийн засгийн талаарх бизнес эрхлэгчдийн хэрэгцээ, шаардлага

4.3.1. Тойрог эдийн засгийн талаарх мэдлэг

Бизнес эрхлэгчдийн ТЭЗ-ийн талаарх дэмжлэгийн хэрэгцээ, шаардлагыг судлахын тулд юуны түрүүнд эхлээд тэдний энэ ойлголтын талаарх мэдлэгийн түвшин, хэрэглээний түвшнийг тодруулах нь чухал юм. Ингэснээр ТЭЗ-ийн үйл явц дахь мэдлэгийн сул хэсэгт анхаарал хандуулах боломжтой болно.

Судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгчид байгаль орчинд ээлтэй, ногоон, хаягдалгүй технологи (тойрог эдийн засаг) гэх ойлголтын талаар 6.5% нь сайн мэднэ, 66.8% нь сонсож байсан, 26.8% нь огт сонсож байгаагүй гэжээ. Энэ нь судалгаанд хамрагдсан хүмүүсийн боловсролын түвшинтэй тодорхой хэмжээнд хамааралтай байна. Тодруулбал, мэдлэг боловсролын түвшин нэмэгдэх тусам ТЭЗ-ийн талаарх мэдлэгийн түвшин нэмэгдэх хандлагатай байна. Харин хот хөдөөгийн хувьд ойлголтын түвшин ялгаагүй байв. Судалгаанд хамрагдсан БЖДБЭ-ийн 2/3 нь ТЭЗ-ийн талаар сонсож байсан гэж хариулсан нь аялал жуулчлалын салбарт тогтвортой, ногоон, байгаль орчинд ээлтэй бизнесийн концепц, чиг хандлага нэвтэрч байгааг харуулж байгаа ч энэ талаар тодорхой, цогц, нарийн ойлголт, мэдлэг бэхжээгүй байна.

Үйл ажиллагааны чиглэлээр харьцуулбал хүнсний үйлдвэрлэл, хоол үйлдвэрлэл болон байраар хангах үйлчилгээ үзүүлэгчдийн ТЭЗ-ийн талаарх тодорхой мэдлэгтэй буюу сонсож байсан гэсэн бол хоол, хүнс, уух зүйлсээр үйлчилгээ үзүүлэгчид болон хүнсний дэлгүүрийн бизнес эрхлэгчид энэ талын ойлголт илүү сул байна. Мэдлэгийн түвшнийг бизнесийн зарим үзүүлэлтээр дараах хүснэгтэд харууллаа (Хүснэгт 5).

Хүснэгт 5. Мэдлэгийн түвшнийг байгууллагын зарим үзүүлэлтээр

Харьцуулах бүлэг	Харьцуулах үзүүлэлт	Сайн мэднэ	Сонсож байсан	Огт мэдэхгүй
Албан тушаал	Захирал	7.5%	68.5%	24.0%
	Эзэмшигч	7.8%	63.8%	28.4%
	Гэр бүлийн бизнес эрхлэгч	0.0%	50.0%	50.0%
	Үйлдвэрийн болон газар хэлтсийн дарга/менежер	0.0%	100.0%	0.0%
	Менежер	4.0%	64.0%	32.0%
	Ахлах ажилтан	15.0%	70.0%	15.0%
	Ажилтан/Мэргэжилтэн	0.0%	78.1%	21.9%
Үйл ажиллагаа явуулж буй жил	1 жил хүртэл	2.4%	56.1%	41.5%
	1-2 жил	2.6%	63.2%	34.2%
	3-5 жил	3.1%	69.4%	27.6%
	6-10 жил	6.9%	73.6%	19.4%
	11-15 жил	10.9%	64.1%	25.0%
	16-20 жил	9.8%	61.0%	29.3%
	21 ба түүнээс дээш жил	10.9%	71.7%	17.4%
Ажилтны тоо	1-10	5.5%	63.9%	30.6%
	10-49	11.3%	76.1%	12.7%
	50-249	5.3%	78.9%	15.8%
Жилийн эргэлтийн хөрөнгө	50 сая ₮ хүртэл	5.4%	62.6%	32.0%
	99 сая ₮ хүртэл	5.9%	62.7%	31.4%
	100-300 сая ₮	9.0%	69.2%	21.8%
	301 сая -500 сая ₮	3.1%	81.3%	15.6%
	501 сая -1 тэр бум ₮	6.3%	87.5%	6.3%
	1 тэрбум ₮ ба түүнээс дээш	15.0%	70.0%	15.0%
Нийт		6.5%	66.8%	26.8%

Үйл ажиллагаагаа удаан эрхэлж буй бизнесүүд ТЭЗ-ийн талаарх ойлголт шинэхэн бизнесүүдтэй харьцуулахад сайн байна. Харин 2 хүртэл жил үйл ажиллагаагаа эрхэлж буй бизнесүүдийн төлөөлөл

ТЭЗ-ийн талаар огт мэдэхгүй гэсэн хариулт өндөр байна. Ажилтны тоо болон эргэлтийн хөрөнгийн хэмжээтэй харьцуулбал бичил, жижиг бизнесүүдийн ойлголт сул, дунд түвшний бизнесүүд харьцангуй ойлголт сайтай байна. Бизнес эрхлэгчдийн албан тушаалаар харьцуулан харвал бүх түвшинд сонсож байсан гэсэн хариулт давамгайлж байна. Захирал, эзэмшигч болон ахлах ажилтнуудын түвшинд “сайн мэднэ” гэж хариулсан хувь бусад албан тушаал хашиж буй хүмүүстэй харьцуулахад өндөр байгаа нь харагдсан.

Зураг 12. Бизнес эрхлэгчдийн ТЭЗ-ийг талаарх ойлголтоо тодорхойлсон байдал



Бизнес эрхлэгчдийн ТЭЗ-ийн талаарх ойлголт нь гол төлөв хог хаягдалтай холбоотой байна. Үүний дараа эрүүл орчин, байгальд ээлтэй хор хөнөөлгүй үйл ажиллагааны талаар дурджээ. Гэхдээ тэдний нэлээд хэсэг нь энэ талын ямар нэг ойлголтгүй байна. Бусад гэсэн хариултад нэг удаа давтагдсан хариултаудыг нэгтгэсэн ба үүнд органик хүнсний хэрэглээ, технологийн шийдэл, хүлэмжийн хий гэх мэт ойлголтуудыг дурджээ.

Мөн ТЭЗ-тай холбогдох дараах ойлголтуудын талаарх тодруулахад Ногоон тэмдэглэгээ болон хог хаягдлын менежментийн талаар тодорхой мэдлэг, мэдээлэлтэй гэж 40 гаруй хувь нь хариулсан. Харин тогтвортой, ногоон санхүүжилт болон ногоон технологийн талаар тийм ч сайн мэдлэггүй байна. Ногоон технологийн талаар илүү ус, дулаанд хэмнэлттэй байх гэсэн хүрээнд л ойлголттой байгаа нь ажиглагдсан. Тогтвортой, ногоон санхүүжилтийн талаар бизнес эрхлэгчдийн 61.8% нь мэдэхгүй байна.

Хүснэгт 6. ТЭЗ-ийн талаар мэдлэгтэй эсэх

№	Утгууд	Мэднэ	Дунд зэрэг	Мэдэхгүй
1	Ногоон тэмдэг (эко шошго, органик тэмдэг, тэмдэглэгээ)	47.5%	28.3%	24.3%
2	Тогтвортой, ногоон санхүүжилт	17.8%	20.5%	61.8%
3	Ногоон технологи, шийдэл	22.0%	30.3%	47.8%
4	Хог хаягдлын менежмент	43.0%	32.3%	24.8%

Бизнесийн чиглэлээр харьцуулан харвал дараах салбаруудын мэдлэг хамгийн сул байна. Үүнд:

- Ногоон тэмдэглэгээний талаар хүнсний үйлдвэрлэл болон сав баглаа боодлын үйлдвэрлэл эрхлэгчдийн мэдлэг сайн, хоол үйлдвэрлэл болон хоол, шингэн хүнсээр үйлчилгээ үзүүлэгчдийн мэдлэг хамгийн сул;
- Тогтвортой ногоон санхүүжилтийн талаар хүнс болон хоолны үйлдвэрлэл, байраар хангах үйлчилгээ эрхлэгчдийн мэдлэг харьцангуй сайн, сав баглаа боодол болон хоол, шингэн хүнсээр үйлчилгээ үзүүлэгчдийн мэдлэг сул;

- Ногоон технологийн талаар шингэн хүнсний үйлдвэрлэлийнхэн болон байраар хангах үйлчилгээ үзүүлэгчдийн мэдлэг сайн, хоол, шингэн хүнсээр үйлчилгээ үзүүлэгчид, хоол үйлдвэрлэлийн бизнесийнхний мэдлэг сул;
- Хог хаягдлын менежментийн талаар шингэн хүнс үйлдвэрлэгчид, сав баглаа боодлын үйлдвэрлэл, байраар хангах үйлчилгээ үзүүлэгчид мэдлэг сайтай, хоол үйлдвэрлэл болон хоол, шингэн хүнсээр үйлчилгээ үзүүлэгчдийн мэдлэг сул байна.

Эдгээрээс дүгнэвэл, ЖДБ-үүдэд тулгамддаг хамгийн том асуудал нь санхүүгийн эх үүсвэрт холбогдох, өндөр хүүтэй зээл зэрэг санхүүжилтийн асуудал байдаг ч ногоон санхүүжилтийн талаарх мэдлэг, мэдээлэл сул байна. Тоон болон чанарын судалгааны үр дүнд бизнес эрхлэгчид, хэрэглэгчид, холбогдох төрийн байгууллагын мэргэжилтнүүд зэрэг талуудын ТЭЗ-ийн талаарх ойлголт хангалтгүй түвшинд байгаа нь ажиглагдсан.

Ялангуяа хог хаягдлыг ангилан ялгах, хог хаягдлын менежментийн талаарх нөлөөллийн ажлууд бага хийгддэг. Энэ чиглэлээр ажилладаг байгууллагууд нөлөөллийн ажлыг зохион байгуулдаг ч төрийн дэмжлэг сул, төсөв хөрөнгө хүрэлцээгүйгээс өргөн хүрээнд хамарч чаддаггүй байна.

Ерөнхийд нь дүгнэвэл, ТЭЗ-ийн талаарх ойлголтыг ТЭЗ-ийн стратегийн үе шатуудын дагуу дүгнэвэл, бизнес эрхлэгчид үйлдвэрлэл, үйл ажиллагааны шат дамжлагуудыг эхлэл болон дараах үе шатуудын талаарх ойлголт хамгийн сул байна. Тодруулбал, бизнес эрхлэгчид үйлдвэрлэл, үйлчилгээний орцыг эхнээс нь үр ашигтай зарцуулах, багасгах, хог хаягдал үүсэхээс сэргийлэх мэдлэг бага байна. Харин шат дамжлагын дундах үйл явцуудад илүү төвлөрч, энэ талаарх ойлголттой байгаа ба үүнтэй холбоотойгоор хог хаягдлыг дахин ашиглах, боловсруулах үйл явцуудад илүү төвлөрч байна. Мөн хэрэглээний дараах эцсийн хэрэглэгчдэд чиглэсэн маркетинг, борлуулалтын шатанд ТЭЗ-ийг ашиглах ойлголт сул байгаа нь ажиглагдлаа.

4.3.2. Тойрог эдийн засгийн талаарх хандлага

Бизнес эрхлэгчид өөрийн бизнесийн салбар дахь байгаль орчинд ээлтэй, ногоон, хаягдалгүй бизнес (ТЭЗ)-ийн ойрын 5 жилийн хөгжлийг үнэлж, цаашдын ач холбогдлын түвшнийг тодорхойлсон. Үүнтэй холбоотойгоор өөрсдийн бизнест шаардлагатай сургалт, зөвлөх үйлчилгээний хэрэгцээгээ тодорхойлж, үр дүнтэй мэдээлэл солилцох арга зам, сувгуудаа илэрхийлсэн.

Бизнес эрхлэгчид ТЭЗ-ийг улсдаа болон салбартаа хөгжүүлэх нь ач холбогдол өндөртэй гэж дүгнэсэн бөгөөд дэлгэрэнгүй үр дүнг доорх зурагт харуулав.


Зураг 13. ТЭЗ-ийг улсдаа болон салбартаа нэвтрүүлэх нь ач холбогдолтой эсэх



Бизнес эрхлэгчид ТЭЗ-ийг салбартаа нэвтрүүлэх нь ач холбогдолтой (96%) гэж үзсэн нь цаашид энэ төрлийн үйл ажиллагааг бизнестээ нэвтрүүлэх сонирхол байгааг илтгэж байна. Тэр дундаа ундааны үйлдвэрлэл эрхлэгчдийн 80% нь, бусад салбарт 50% орчимтой "маш их ач холбогдолтой" гэж үзсэн бол хоол, ус ундаагаар хангах үйлчилгээ эрхлэгчдийн цөөн хувь нь "дунд зэрэг" болон "мэдэхгүй" гэсэн хариулт өгсөн. Ер нь бизнес эрхлэгчид цаашид ТЭЗ-ийг хөгжих нь тодорхой зүйл гэж үзэх хандлагатай байна.

Бизнес эрхлэгчдийн 91.3% нь эрхэлж буй бизнесийн үйл ажиллагаагаа байгаль орчинд ээлтэй байдлаар хөгжүүлэх сонирхолтой байгаагаа илэрхийлжээ. Ердөө 2.3% нь сонирхолгүй болон хэлж мэдэхгүй гэсэн хариулт өгсөн.


Зураг 14. Бизнесээ цаашид байгальд ээлтэйгээр хөгжүүлэх сонирхол



Энэхүү үр дүн бизнес эрхлэгчдийн бизнесийн чиглэл, хэлбэр, хугацаа, үйл ажиллагааны тогтвортой байдал зэрэг ерөнхий үзүүлэлтүүдээс хамаарсан ялгаа ажиглагдсангүй. Харин судалгаанд оролцогчдын "ТЭЗ гэсэн ойлголтыг өмнө сонсож байсан эсэх"-ээс нь хамаарсан ач холбогдол бүхий ялгаатай байдал ажиглагдсан. Өөрөөр хэлбэл уг ойлголтыг өмнө сонсож байсан буюу сайн мэдэх бизнес эрхлэгчдийн цаашид бизнесийн үйл ажиллагаагаа байгаль орчинд ээлтэй байдлаар хөгжүүлэх сонирхол илүү өндөр байна.

Бизнес эрхлэгчид цаашдаа өөрийн бизнесийн салбар дахь ТЭЗ-ийн ойрын хугацааны хөгжлийг ихэвчлэн сайн болон дунд түвшинд хөгжсөн байна гэж төсөөлж байна.


Зураг 15. ТЭЗ-ийн хөгжлийн ойрын 5 жилийн төсөөлөл



Судалгаанд оролцогчид өөрийн бизнес эрхэлж буй салбарын байгаль орчинд ээлтэй, ногоон, хаягдалгүй бизнес (ТЭЗ)-ийн хөгжлийг үнэлсэн үнэлгээ салбар бүрээр харилцан адилгүй байна. Тухайлбал, сав баглаа боодол, ундааны үйлдвэрлэл эрхэлж буй бизнес эрхлэгчид 50%-аас дээш “сайн хөгжсөн” гэсэн хариулт өгсөн бол хоол, ус ундаагаар хангах үйлчилгээ үзүүлэгчид 12%-тай маш сайн болон сайн хөгжсөн гэсэн байдлаар үнэлгээ өгчээ. Ихэнх салбарт бизнес эрхлэгчид ТЭЗ-ийн хөгжлийг дунд шатандаа явж байгаа гэсэн үнэлэлт өгсөн бөгөөд цаашид хөгжүүлэх хэрэгцээ шаардлага байгааг илтгэсэн.

Цаашид байгаль орчинд ээлтэй, ногоон, хаягдалгүй бизнес (ТЭЗ)-ийг хөгжүүлэхэд шаардлагатай хүчин зүйлсийн ач холбогдолд өгсөн бизнес эрхлэгчдийн хариултын үр дүнг дараах дүрсээр харуулав.

Зураг 16. ТЭЗ-ийг хөгжүүлэхэд шаардагдах хүчин зүйлсэд өгч буй ач холбогдол



Бизнес эрхлэгчид судалгаанд дурдагдсан хүчин зүйлс тус бүрийн ач холбогдлын түвшнийг 93 ба түүнээс дээш хувьтай “чухал” ба “маш чухал” гэж үзжээ. Тэр дундаа санхүүгийн үйлчилгээ, мэдлэг,

мэдээлэл олгох үйл ажиллагааны ач холбогдлыг өндөр хувьтай “маш чухал” гэж хариулсан байна. Энэхүү үр дүн бизнес эрхлэгчдийн бизнесийн чиглэл, хэлбэр, хугацаа, үйл ажиллагааны тогтвортой байдал зэрэг ерөнхий үзүүлэлтүүдээс хамаарсан ялгаа ажиглагдсангүй.

Чанарын мэдээллээс тодруулан харвал жуулчны бүсэд үйл ажиллагаа явуулж буй үйлчилгээний газрууд үйл ажиллагаандаа ТЭЗ-ийн хандлагыг нэвтрүүлэх сонирхол илүү байгаа нь ажиглагдсан. Учир нь гаднын жуулчид ТЭЗ-ийн талаарх стандарт, үйл ажиллагааны чиглэлээр санал, шаардлага тавих нь элбэг байдаг аж.

Шигтгээ 1. Гадаад аялагчид аялал жуулчлалын салбарт ТЭЗ-ийг хэрэгжүүлдэг эсэх талаар сонирхдог

Энэ талын мэдлэгтэй аялагч нар жил ирэх бүр нэмэгдэж байна. Аялагч нар нь өөрсдөө хогоо ангилж ялгах газар танайд байдаггүй юм уу, автомат удирдлагын систем байхгүй юу, үйл ажиллагаандаа байгальд ээлтэй гэсэн ямар нэг баримтжуулалт авдаг уу гэх зэргээр шаардлага тавиад ирэхээр газрууд нь дагаад өөрсдийнхөө чадах хэмжээнд өөрчлөгддөг юм байна гэж байсан. Харин хотод аялагчид ийм шаардлага бараг тавьдаггүй.

Бизнес эрхлэгчдийн ярилцлагаас


4.3.3. Тойрог эдийн засгийн талаарх туршлага

Судалгаанд хамрагдсан бизнесүүдийн тал хувь нь (49.8%) байгаль орчинд ээлтэй, ногоон, хаягдалгүй (ТЭЗ) бизнесийн үйл явцыг ямар нэг хэмжээгээр үйл ажиллагаандаа ашигладаг гэжээ. Тухайлбал,

- Бүтээгдэхүүн үйлчилгээндээ байгалийн гаралтай материал ашигладаг – 11.5%
- Хог хаягдлыг бордоо болгодог – 7.8%
- Хог хаягдлыг малын тэжээл болгодог – 13.8%
- Хог хаягдлыг дараагийн шатны боловсруулах үйлдвэрт өгдөг – 10% гэх мэт олон төрлийн үйл ажиллагааг нэрлэж байна.

Гэхдээ 17%-д нь л байгаль орчинд ээлтэй, ногоон, хаягдалгүй үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэхэд чиглэсэн бодлогын баримт бичиг, төсөв, төлөвлөгөө байдаг гэж хариулсан. Эдгээрийн ихэнх нь байгууллагын эрхэм зорилго хүрээнд боловсруулсан байна. Энэ нь бизнесүүд цаашдаа тогтвортой хөгжилд чиглэсэн бизнесийн бодлого төлөвлөлтийг хийх болсныг илтгэж байна.

Зураг 17. Бизнес нь ТЭЗ-тай холбогдох бодлогын баримт бичиг байгаа эсэх, байгаа бол боловсруулсан шалтгаан



Судалгаанд хамрагдсан бизнесүүдийн холбогдох мэргэжилтэн, хүний нөөцийн 24.5% нь байгаль орчинд ээлтэй, ногоон, хаягдалгүй байхтай холбоотой сургалтад хамрагдаж байсан гэжээ. Энэ чиглэлийн сургалтад хамрагдаж байсан бизнесүүдийн төлөөллийн тал хувь нь ТЭЗ-ийн ойлголтын талаар сайн мэднэ гэж хариулсан хэсэгт багтаж байгаа нь сургалт, мэдээлэл зөвлөгөө нь мэдлэгийг нэмэгдүүлэхэд ихээхэн чухал болохыг харуулж байна.

Ямар төрлийн сургалтуудад хамрагдсаныг тодруулбал яам, орон нутгаас зохион байгуулсан сургалтууд, түүн дотроо хогоо ангилах ялгах сургалтууд, төслийн болон хувийн хэвшлийн хүрээнд хэрэгжүүлж буй хогоо ангилах, дахивар бүтээгдэхүүнээ авах, ногоон санхүүжилт, эко хоол хүнсний зэрэг олон төрлийн сургалтуудыг нэрлэжээ. Үүнээс хог хаягдлын менежментийн сургалтын сэдвүүд ихэнх хувийг эзэлж байна.

Бизнес эрхлэгчдийн 31.5% нь сүүлийн 5 жилийн хугацаанд байгальд ээлтэй ТЭЗ-ийн чиглэлээр ямар нэг тоног төхөөрөмж, технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн бизнесийг мэднэ гэжээ. Ямар шийдэл нэвтрүүлсэн талаар тодруулахад:

- Эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмж – 8%
- Хогоо дахин боловсруулалт – 7.5%
- Бохироо соруулдаг, био технологи, саарал ус – 3.5%
- Нарны эрчим хүч – 2.3%
- Органик сав баглаа боодол – 1.8%
- Усны хэмнэлттэй технологи, уураар угаагч – 2.1%
- Газ, эрчим хүчний хэмнэлттэй хөргөгч – 1.3%
- Мод тарих, ногоо байгууламж – 0.8%
- Нэг удаагийн хэрэглээнээс татгалзах – 0.5% гэх мэт хариултуудыг хамгийн өндөр давтамжтай нэрлэжээ.

Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг газрууд хог хаягдлын менежментээ сайжруулж илүү хариуцлагатай хандаж буй жишээнүүд чанарын судалгаанд хамрагдсан. Эдгээрээс сургалт, зөвлөгөөний үйл ажиллагаанд кейс, жишээ хэлбэрээр ашиглах, туршлага судлах боломжийг эрэлхийлэх нь үр дүнг нэмэгдүүлэх талтай. Тиймээс сайн жишээ бүхий кейсүүдийг Хавсралт 1-д оруулж өгсөн тул дэлгэрэнгүйг тэндээс харна уу.

4.3.4. Тойрог эдийн засгийн боломжуудыг нэвтрүүлэхэд тулгарч буй саад бэрхшээлүүд

Судалгаанд оролцсон бизнес эрхлэгчид өөрийн бизнесийг байгаль орчинд ээлтэй, ногоон хаягдалгүй байдлаар хэрэгжүүлэхэд тулгардаг бэрхшээлийг дараах байдлаар нэрлэжээ.

Хүснэгт 7. Бизнесээ ТЭЗ-ийг нэвтрүүлэхэд тулгарч буй бэрхшээл

№	Бизнесийн үйл ажиллагааг байгаль орчинд ээлтэй, ногоон хаягдалгүй байдлаар хэрэгжүүлэхэд тулгардаг саад бэрхшээл	Хариултын хувь
1	Эдийн засаг, санхүүгийн нөөц дутагдалтай, дэмжлэг авах боломж хязгаарлагдмал	59.0%
2	Хөрөнгө оруулалт дутмаг	52.0%
3	Байгальд ээлтэй технологийн сүүлийн үеийн хөгжил, тойрог эдийн засгийн талаарх дэлхий, бүс нутаг, үндэсний чиг хандлагатай холбоотой мэдээллийн хүртээмж муу	49.5%
4	Тойрог эдийн засаг, түүнийг хэрэгжүүлэх дизайн, стратеги, шийдэлтэй холбоотой мэдээлэл дутмаг	46.3%
5	Одоогийн хууль тогтоомжийн дэмжлэг, урамшуулал, хөшүүрэг тун муу	44.0%
6	Байгууллага, төрийн байгууллагууд, түншүүд, хэрэглэгчдийн хооронд мэдлэг солилцох чадвар дутмаг	38.8%
7	Шинэ зах зээлд нэвтрэх, тэлэх дэмжлэг дутмаг	38.5%
8	Монголд нийлүүлэлтийн сүлжээнд хамаарах тогтвортой бэлтгэн нийлүүлэгчдийн тоо хязгаарлагдмал	36.8%
9	Юу хийх, хаанаас эхлэхээ сайн мэддэггүй	36.3%
10	Богино хугацааны, тогтворгүй улс төрийн өөрчлөлт	32.3%
11	ТЭЗ-тай холбоотой үйлчилгээ үзүүлэх чадвартай дотоодын бизнес эрхлэгчид бага	31.0%
12	ТЭЗ-ийн шийдлийг компанид хэрэгжүүлэхэд зардал их гарах хандлагатай байдаг	25.5%
13	Удирдлагын дээд түвшний манлайлал, дэмжлэг дутмаг	25.3%

14	Удирдлагын баг, ажилчдын мэдлэг, ур чадвар, туршлага муу	24.8%
----	--	-------

Бизнес эрхлэгчид өөрсдөд нь тулгардаг бэрхшээлүүдээс эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын холбогдолтой бэрхшээлүүдийг түлхүү дурджээ. Мөн оролцогчдын тал орчим хувь нь сэдвийн холбогдолтой олон улсын хандлага, технологийн мэдээлэл болон ТЭЗ-ийг хэрэгжүүлэхэд чиглэсэн арга зүйн мэдлэг шаардлагатай байдаг болохоо онцолсон. Харин ТЭЗ-ийн шийдлийг компанид хэрэгжүүлэхэд чиглэсэн дотоод асуудал болон байгууллагын удирдлагын манлайлал, дэмжлэг, баг ажилтнуудын мэдлэг ур чадвартай холбогдсон асуудлыг бусад бэрхшээлтэй харьцуулахад бага хувьтай дурдсан ч судалгаанд оролцогчдын 25 орчим хувийг эзэлжээ. Энэхүү үр дүн бизнес эрхлэгчдийн бизнесийн чиглэл, хэлбэр, хугацаа, үйл ажиллагааны тогтвортой байдал зэрэг ерөнхий үзүүлэлтүүдээс хамаарсан ялгаа ажиглагдсангүй.

Тоон болон чанарын судалгааны үр дүнгээс харвал төр, бизнес эрхлэгчид, ТЭЗ-ийг хэрэгжүүлж буй мэргэжлийн байгууллагуудын хоорондын уялдаа холбоо сул байна. Төрөөс энэ чиглэлд бизнесүүдэд чиглэсэн дэмжлэг сул, ялангуяа ТЭЗ-ийг хэрэгжүүлэгчдэд зориулсан дэмжлэг сул учраас олон нийтэд мэдээлэл хүргэх, нөлөөллийн ажлууд хийх боломж хязгаарлагдмал, бизнес эрхлэгчид энэ чиглэлийн мэдээлэл сул байна.

Шигтгээ 2. Орон нутагт хог хаягдлын менежментийг хийхэд манлайлал дутагдаж байна.

Хог хаягдал, жуулчны талаар манлайлал хийж байгаа хүмүүс бараг байхгүй. Мэдлэг ойлголт муу учраас тийм байдаг байх гэж боддог. Мэдлэггүйгээс гадна ангилан ялгалаа гэж бодоход очиж авдаг хүргэлтийн систем байхгүй. Өөрсдөө аваачиж өгөх боломжтой боловч дадал суугаагүй. Сумдад хоёрдогч түүхий эд авдаг цэг ховор. Мөрөн суманд л байдаг. Бусад суманд байхгүй. Хог хаягдлын цэг байгуулаад хоёрдогч түүхий эд авах бизнес руу орох хүсэлтэй хүмүүс ховор байдаг. Хог хаягдлын олон нийтийн байцаагч ажиллуулах гэхээр сум орон нутгаас хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх тал дээр муу. Мөнгө санхүүгийн асуудлаас болоод сайн зүйлс хийж чаддаггүй байх.

Хөвсгөл аймгийн БОАЖГ-ийн мэргэжилтэн

Шигтгээ 3. ТЭЗ-ийг хэрэгжүүлж буй ТББ-ын туршлага, тулгарч буй бэрхшээл

Ангилсны дараа ангилсан дахивар түүхий эдийг нь авна гэдэг маш том ажил байдаг. Хогоо ангилж ялгаарай гэж хэлээд дахиврыг нь авахгүй байх юм бол энэ ажил үргэлжлэхгүй. Айл өрхүүдийн хог хаягдлын 60-70% нь дахивар байдаг бол аялал жуулчлалын баазаас 80-90% нь дахивар гардаг. Тэр дундаа архи, ус, ундааны сав, гялгар уут их хэмжээгээр гардаг.

Бодлогын орчин дутагдалтай байгаа. Нийслэлд хогийг айлаас аваад хогийн цэгт аваачихад төрийн зүгээс дөчөөд тэрбум төгрөгийн зарцуулдаг. Гэтэл айлын хашаанаас дахин боловсруулаад баялаг болгоод дахин боловсруулах үйлдвэрүүдэд аваачихад маш олон ажлын байр бий болгоод, байгаль орчино хамгаалдаг. Дахин боловсруулах салбарт ядаж бензиний зардлын 4 тэрбум ч юм уу эвэл хэдэн сая төгрөгийг зарцуулаад бодит хөрөнгө оруулалт хийвэл монгол орон хогноосоо сална. Нийгэмд эерэг нөлөө авч ирж байгаа энэ салбарт зуун мянган төгрөгийн ч дэмжлэг байхгүй. Хог хаягдлын тухай хууль гарсан байгаа. Хуульд хүн болгон хогоо ангилан ялгах ёстой гэсэн байгаа. Мөн нийслэл, аймгийн засаг дарга нар хог хаягдал дахин боловсруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа компани, төрийн бус байгууллагатай хамтраад төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, эдгээрийг санхүүжүүлэх зүйл заалт байгаа ч үүнийг хэрэгжүүлээгүй байгаа.

Бид Чингэлтэйн хороодтойгоо бол танайх мэдээллээ сайн өгөөрэй бид дахиврыг авъя гэх байдлаар харьцдаг.

Бид сая 10,11-р сард Тэрэлжид байдаг аялал жуулчлалын хэд хэдэн баазуудтай хамтраад ялгасан дахиврыг нь нэг явахдаа тууш байдлаар бүгдийн авъя гээд ажил хэрэг болгохоор тохироод байгаа. Манайхтай долоо найман бааз хамтарч ажиллахаар болоод энэ 5-р сард үйл ажиллагаа эхлээд ирэхээр хогоо өгч байя, хог ангилах хогийн сав хийдэг газруудтай холбоод өгөөч гэсэн. Тэрэлжийн баазуудад бид дахиврыг чинь мөнгөөр авахгүй, бензиний зардлаа 50,50 хувиар гаргана гэж тохирсон. Бид нар яваад очиход хол учраас заардлаа даахгүй байгаа тул ийм байдлаар гэрээ хийгээд ажиллана гэсэн байгаа. Одоо 5-р сард энэ ажил эхлэх байхдаа.

Шигтгээ 4. ТЭЗ-ийг хөгжүүлэхэд бодлогын хүрээнд тулгамдаж буй бэрхшээл

ЖДҮ тухай хуулийн дагуу зээл 2010 онд олгож эхэлсэн. Үүнд дахин боловсруулах салбарыг оруулдаггүй, сав баглаа боодлын салбар ордог. Сав баглаа бол бэлэн бүтээгдэхүүн хэлбэрээр орж ирдэг. Үүн дээр гаалийн албан татвараас чөлөөлж байна. Гэтэл хог хаягдлын салбар гадаадаас оруулж ирсэн хог хаягдлын бүтээгдэхүүнийг эргэлтэд оруулдаг. Иргэд, хогийн цэгүүд и-баримт төлөхгүй цаашаа үйлдвэрт өгөхөд и-баримт бөглөх болохоор асуудалд орж байгаа. Энийг эхлээд чөлөөлөх хэрэгтэй. Нэмэгдсэн өртгийн албан татвар ногоо, ноосонд анхны НӨАТ-ын 10% шингэсэн гэж үзнэ гэж заасан байдаг. Ингэж үзэх хэрэгтэй. Хог боловсруулаад баялаг бүтээсэн улсуудыг борлуулалтын НӨАТ-ын албан татвараас чөлөөлөх хэрэгтэй. Ингэж энэ салбарын хөгжлийг дэмжинэ.

Хог хаягдлыг бууруулах үндэсний холбоо ТББ

4.3.5. Тойрог эдийн засгийн талаарх сургалт, дэмжлэгийн хэрэгцээ

Бизнес эрхлэгчдээс байгаль орчинд ээлтэй, ногоон, хаягдалгүй бизнес (ТЭЗ)-ийн зарчмуудаас юуг нь илүү өөрийн бизнесийн үйл ажиллагаанд нэвтрүүлж, хөгжүүлэхийг зорьж буй талаар асууж, нээлттэй хариултууд авсан.

Зураг 18. ТЭЗ-ийг өөрийн бизнестээ нэвтрүүлэхийг хүсэж буй чиглэл



Судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн талаас илүү хувь нь “хогоо ангилах, дахин боловсруулах”, “хог хаягдлын менежментийг сайжруулах” чиглэлээр юун түрүүнд ажиллах сонирхолтой байгааг илэрхийлсэн. Мөн ногоон байгууламж бий болгох, ус хэмнэх, зохистой ашиглах, цахилгаан эрчим хүчний хэмнэлт гаргах гэх мэт асуудалд анхаарч байгаагаа цөөн тооны бизнес эрхлэгчид дурдаж байв.

Бизнесүүд ТЭЗ-ийн чиглэлээрх сургалт, зөвлөх үйлчилгээний хэрэгцээ, шаардлагыг өндөр хувьтай (81.9%) байна гэж үзсэн.

Хүснэгт 8. Сургалт, зөвлөх үйлчилгээний хэрэгцээг бүлгээр харьцуулсан мэдээлэл

Харьцуулах бүлэг	Харьцуулах үзүүлэлт	Хэрэгцээ байна гэсэн %
	Хүнсний үйлдвэрлэл	80.4%

Үйл ажиллагааны чиглэл	Ундааны үйлдвэрлэл /хийжүүлсэн ундаа, ус, жүүс гэх мэт... /	94.2%
	Хоол үйлдвэрлэл, үйлчилгээ (хоолны газар, ресторан гэх мэт)	81.0%
	Сав баглаа боодол (хуванцар)	90.4%
	Байраар хангах үйлчилгээ үзүүлэгч (зочид буудал, жуулчны бааз гэх мэт)	82.4%
	Хоол, ус ундаагаар хангах үйлчилгээ үзүүлэгч (ресторан, шөнийн цэнгээний газар, гудамжны хоол гэх мэт)	77.6%
	Хүнсний дэлгүүр	84.8%
Албан тушаал	Захирал	85.1%
	Эзэмшигч	80.0%
	Гэр бүлийн бизнес эрхлэгч	92.8%
	Үйлдвэрийн болон газар хэлтсийн дарга/менежер	100.0%
	Менежер	79.0%
	Ахлах ажилтан	77.1%
	Ажилтан/Мэргэжилтэн	81.9%
Байршил	Хот	78.9%
	Хөдөө	91.4%
Нийт		81.9%

Сургалт, зөвлөх үйлчилгээний хэрэгцээ шаардлагыг ундаа болон сав, баглаа боодлын үйлдвэрлэл эрхлэгчид 90 ба түүнээс дээш хувьтай байна гэж үзсэн бол эсрэгээр хоол, ус ундаагаар хангах үйлчилгээ үзүүлэгчид бусад чиглэлийн бизнес эрхлэгчидтэй харьцуулахад хамгийн бага хувьтай (77.6%) хэрэгцээ шаардлагаа илэрхийлжээ. Хөдөө, орон нутгаас судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдэд сургалт, зөвлөх үйлчилгээний хэрэгцээ шаардлага Улаанбаатар хотын бизнес эрхлэгчдээс илүү өндөр байгаа нь харагдлаа. Мөн гэр бүлийн бизнес эрхлэгчдэд сургалт, зөвлөх үйлчилгээний хэрэгцээ илүү өндөр байгааг дээрх хүснэгтээс харж болох юм.

Бизнес эрхлэгчдэд шаардлагатай байгаа хэрэгцээг сургалт болон зөвлөх үйлчилгээ гэсэн ангиллаар салгаж, тодорхой сэдвийн дагуу үнэлүүлсэн мэдээллийг дараагийн зургаар харууллаа. Сургалт болон зөвлөх үйлчилгээ гэсэн ангиллын дагуу хэрэгцээнд ач холбогдол бүхий ялгаатай байдал ажиглагдаагүй. Хог хаягдлын менежмент, тогтвортой, ногоон санхүүжилтийн тухай болон бусад холбогдолтой мэдлэг, мэдээлэл өгөх төрлийн ажлуудад илүү сургалтын ажил зохимжтой байж болох юм. Харин стандарт нэвтрүүлэх, гэрчилгээ авах, тогтвортой тойрог бүтээгдэхүүний дизайн боловсруулах зэрэг ажлуудад зөвлөх үйлчилгээний дэмжлэг авах нь зохимжтой байх магадлалтай.

Зураг 19. ТЭЗ-ийн шийдлүүдийн талаарх сургалт, зөвлөх үйлчилгээний хэрэгцээ



Судалгааны хүрээнд санал болгосон сургалтын сэдвүүдийн хэрэгцээ шаардлагыг бизнес эрхлэгчид өндрөөр үнэлсэн. Ялангуяа “тогтвортой, ногоон санхүүжилт” гэсэн ойлголт болон хог хаягдлын менежмент, үйлдвэрлэл, үйлчилгээний холбогдолтой сургалтын хэрэгцээ шаардлагыг бусад сэдэвтэй харьцуулахад өндөр байна гэжээ. Хог хаягдлын менежмент, үйлдвэрлэл, үйлчилгээний холбогдолтой сургалтад хамгийн их хувьтай хамрагдаж байсан, цаашид ч мөн энэ чиглэлээр сургалтад хамрагдах хэрэгцээ шаардлага өндөр гэсэн нь тухайн сэдвийн ач холбогдол хэр чухал болохыг харуулж байна. Дээрх асуулт бүрийг бизнес эрхлэгчдийн бүлэг, үзүүлэлт тус бүрээр харьцуулсан мэдээлэлтэй дараагийн хүснэгтээс танилцах боломжтой.

Хүснэгт 9. Сургалт зөвлөх үйлчилгээний сэдвүүдийг бизнес эрхлэгчдийн бүлэг, үзүүлэлтээр харьцуулсан мэдээлэл

Харьцуулах бүлэг	Харьцуулах үзүүлэлт	A4 ¹⁷	A3	A2	A1	A6	A5	A7
Байршил	Хот	82%	80%	70%	68%	85%	83%	86%
	Аймаг	97%	89%	84%	84%	94%	95%	98%
Албан тушаал	Захирал	88%	86%	77%	74%	89%	90%	92%
	Эзэмшигч	85%	80%	74%	72%	82%	80%	87%
	Гэр бүлийн бизнес эрхлэгч	90%	100%	90%	80%	100%	90%	100%
	Үйлдвэрийн болон газар хэлтсийн дарга/ менежер	100%	100%	100%	100%	100%	100%	100%
	Менежер	81%	79%	68%	68%	85%	87%	85%
	Ахлах ажилтан	90%	90%	45%	50%	95%	80%	90%
	Ажилтан/Мэргэжилтэн	84%	69%	75%	75%	88%	84%	81%
Үйл ажиллагааны чиглэл	Хүнсний үйлдвэрлэл	81%	84%	73%	77%	84%	80%	86%
	Ундааны үйлдвэрлэл /хийжүүлсэн ундаа, ус, жүүс гэх мэт... /	80%	100%	100%	80%	100%	100%	100%
	Хоол үйлдвэрлэл, үйлчилгээ (хоолны газар, ресторан гэх мэт)	87%	80%	74%	70%	85%	83%	89%
	Сав баглаа боодол (хуванцар)	100%	83%	83%	83%	83%	100%	100%

¹⁷ Зураг 16-аас Сургалт, зөвлөх үйлчилгээний сэдэв агуулгын харгалзах дугаарлалтыг тулгаж харах боломжтой.

Байраар хангах үйлчилгээ үзүүлэгч (зочид буудал, жуулчны бааз гэх мэт)	87%	84%	70%	71%	88%	89%	88%
Хоол, ус ундаагаар хангах үйлчилгээ үзүүлэгч (ресторан, шөнийн цэнгээний газар, гудамжны хоол гэх мэт)	81%	69%	69%	63%	94%	88%	81%
Хүнсний дэлгүүр	85%	85%	79%	71%	91%	91%	91%

Харин цаашид байгаль орчинд ээлтэй, ногоон, хаягдалгүй бизнес (ТЭЗ)-ийн шийдлүүдийг ашиглахад шаардагдах дэмжлэгүүдийг бизнес эрхлэгчид дараах байдлаар тодорхойлж байна.

Зураг 20. ТЭЗ-ийн шийдлүүдийг ашиглахад шаардагдах дэмжлэгийн хэрэгцээ



Байгаль орчинд ээлтэй, ногоон, хаягдалгүй бизнес (ТЭЗ)-ийн шийдлүүдийг өөрийн бизнесийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх явцад санхүүгийн нэмэлт эх үүсвэр бий болгох чиглэлээрх дэмжлэг шаардлагатай байгааг судалгаанд оролцогчдын 90% гаруй нь онцолжээ. Тухайн хариултад компанийн сар, жилийн эргэлтийн хөрөнгөөс хамаарсан ач холбогдол бүхий ялгаа ажиглагдаагүй ч хөрөнгийн хэмжээ өсөх тусам нэмэлт санхүүгийн эх үүсвэртэй холбогдолтой дэмжлэг шаардлагатай гэж үзэх хувь өсөх хандлагатай байв. Мөн холбогдолтой үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн хууль эрх зүйн орчинд ахиц гаргах шаардлагатай болохыг судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн 87% дурдсан. Энэ нь байгаль орчинд ээлтэй, ногоон, хаягдалгүй бизнес (ТЭЗ)-ийн шийдлүүдийг нэвтрүүлж буй санал, санаачилгуудыг дэмжих, урамшуулахтай илүү холбогдоно гэдгийг судалгаанд оролцогчид нэмэлт тайлбараар онцлон дурдаж байв. Ялангуяа хүнсний дэлгүүр, хоол, ус ундаагаар хангах үйлчилгээ, байраар хангах үйлчилгээ, хоол үйлдвэрлэлийн үйлчилгээ эрхлэгчдийн хувьд 90 ба түүнээс дээш хувьтай "дэмжихэд чиглэсэн хууль эрх зүйн орчин"-г сайжруулах гэсэн саналтай байв.

4.3.6. Сургалтын зохион байгуулалт

ТЭЗ-ийн чиглэлээр сургалт, зөвлөгөө зохион байгуулахдаа ямар аргачлал, ямар сувгийг ашиглавал үр дүнтэй болох талаар бизнес эрхлэгчид дараах байдлаар саналаа илэрхийлсэн.

Сургалтын зохион байгуулалтын талаар байршлаар харьцуулан харахад аргачлал болон мэдээлэл хүлээн авах суваг нь зарим ялгааг харуулж байна.

Улаанбаатарын бүсэд үйл ажиллагаа явуулж буй бизнесүүд сургалт, зөвлөгөөг илүү лекц хэлбэрээр авах хүсэлтэй байхад орон нутгийнхан илүү практикт суурилсан аргачлалыг хүсэж байна. Гэхдээ аль аль нь сайн туршлага судлах, харилцан ярилцах байдлаар илүү бодит туршлагад суурилсан хэлбэрээр сургалт болон зөвлөгөөг авах хүсэлтэй байна. Сургалтын хэрэгцээ нь тухайн сэдвийн талаарх мэдлэг, ойлголт өгөхөөс гадна түүнийг тэдний бизнест хэвшүүлэх, дадал болгох нь илүү үр дүнтэй, хэрэгцээтэй

ажил болох нь харагдаж байна. Тиймээс сургалт, менторын үйл ажиллагааг өөрсдийн бизнест нь суурилсан, жишээлсэн байдлаар зохион байгуулбал илүү үр дүнтэй болох магадлалтай.

Зураг 21. Сургалт зохион байгуулах аргачлал, %



Зураг 22. Сургалт, зөвлөгөөний мэдээлэл хүлээн авах суваг, %



Сургалт, зөвлөгөөг хотод фейсбүүк группээр дамжуулан авах нь илүү хурдан, хүртээмжтэй гэж үзсэн. Хөдөө, орон нутгийн иргэд холбогдох газар, мэргэжилтнээс шууд нүүр тулсан байдлаар мэдээлэл авахыг бусад арга замтай харьцуулахад хамгийн өндөр хувьтай илүүд үзжээ (Зураг 22). Гэхдээ аль ч тохиолдолд фейсбүүк платформоор дамжуулан мэдээлэл шууд хүргэх арга ашиглах нь тохиромжтой байна.

4.3.7. Хүлээлт

Бизнес эрхлэгчид үйлдвэр үйлчилгээндээ ногоон технологи ашиглаж, ТЭЗ-ийн загварт шилжсэнээр өөрийн бизнестээ гарах өөрчлөлтийг нэн тэргүүнд “нийгмийн хариуцлага нэмэгдэж, бусдад үлгэр дуурайл болно” гэсэн үүднээс харсан байна. Дэлгэрэнгүй үр дүнтэй дараах зургаас танилцах боломжтой.

Зураг 23. ТЭЗ-ийн загварт шилжсэнээр гарах өөрчлөлтийн талаарх төсөөлөл



Бусад эерэг өөрчлөлтүүдийг судалгаанд оролцсон бизнес эрхлэгчид 30%-50% хооронд дурдсан бөгөөд ашиглалт болон үйлдвэрлэл, үйлчилгээтэй холбоотой зардлууд буурна гэсэн хүлээлттэй байгаа нь харагдаж байна. Бизнесийн үйлчилгээнд гарах эерэг өөрчлөлтүүдийг дурдсан үр дүнд бизнесийн чиглэл, хэлбэр, хугацаа, үйл ажиллагааны тогтвортой байдал зэрэг ерөнхий үзүүлэлтүүдээс хамаарсан ялгаа ажиглагдсангүй.

5. Дүгнэлт ба зөвлөмж

Судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн дунд ТЭЗ гэх ойлголт хангалтгүй түвшинд байгаа ба ихэнх нь сонсож байсан төдийгөөр мэдлэг нь хязгаарлагдаж байна. ТЭЗ-ийн талаарх оролцогчдын ойлголтод бизнесийн чадамж (ажилтны тоо, эргэлтийн хөрөнгө, ажилласан хугацаа гэх мэт) болон судалгаанд оролцогчдын албан тушаал, боловсролын түвшнээс хамаарсан ялгаатай байдал ажиглагдсан. Иймд ТЭЗ-ийн талаарх чадавхжуулах үйл ажиллагаа (сургалт, зөвлөх үйлчилгээ гэх мэт)-г нэн тэргүүнд жижиг, дунд түвшний бизнесүүдэд чиглүүлэх бодит шаардлага байна.

Бизнес эрхлэгчид цаашид ТЭЗ-ийг улсдаа болон салбартаа хөгжүүлэх асуудалд өндөр ач холбогдол өгч байгаа ба өөрийн бизнестээ нэвтрүүлэх сонирхол их байна. ТЭЗ-ийг цаашид хөгжүүлэхийн тулд санхүүгийн үйлчилгээнд холбон нэвтрүүлэх, мэдлэг ойлголт нэмэгдүүлэх болон туршлага солилцох үйл ажиллагааг зохион байгуулах, хууль эрх зүйн орчинд шаардлагатай сайжруулалтыг хийж гүйцэтгэх нь чухал ач холбогдолтой болохыг дурдсан. Иймд бизнес эрхлэгчдийг ТЭЗ-ийн талаарх мэдлэг мэдээлээр хангах, өөр хооронд нь холбон зуучлах, бусад оролцогч талуудтай сонирхол үйл ажиллагааг нь уялдуулах, үйл ажиллагаанд хяналт, баталгаажуулалт хийхэд чиглэсэн нэгдсэн менежментийн тогтолцоог үүсгэх хэрэгцээ байна.

Судалгаанд хамрагдсан 4 байгууллага тутмын 1 нь тухайн чиглэлийн холбогдолтой сургалтад хамрагдсан байгаа ба ихэнх нь хог хаягдлын менежмент, түүнийг ангилах, дахин боловсруулахтай холбоотой сургалтууд байна. Мөн 5 байгууллага тутмын 1 нь байгаль орчинд ээлтэй, ногоон, хаягдалгүй үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд чиглэсэн бодлогын баримт бичиг, төсөв, төлөвлөгөө боловсруулдаг туршлагатай байна. Эдгээр нь ихэвчлэн ISO стандарт нэвтрүүлэх, байгууллагын зардал бууруулах, ашгийн түвшнийг нэмэгдүүлэхэд чиглэн боловсруулагджээ. Үүнээс үзэхэд цаашид тогтвортой хөгжил, ТЭЗ-ийн агуулгаар шууд чиглэсэн сургалт, зөвлөх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, хувь бизнес бүрд энэ чиглэлийн бодлого, төлөвлөлтийн ажлуудыг нэвтрүүлэх шаардлага байгааг харж болно.

Бизнес эрхлэгчдэд ТЭЗ-ийн холбогдолтой үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын холбогдолтой бэрхшээлүүд түлхүү тохиолдож байна. Мөн арга зүй, техник технологийн мэдлэг боловсрол дутагдалтай байдаг нь ТЭЗ-ийн шийдлийн өөрсдийн үйл ажиллагаанд нэвтрүүлэхэд бэрхшээл үүсгэдэг аж. Иймд ТЭЗ-ийн холбогдолтой чиг үүргийг хэрэгжүүлж буй төрийн институци, мэргэжлийн байгууллага, бизнес эрхлэгчид гэсэн талуудын уялдаа холбоо, хоорондын мэдээлэл солилцох арга замуудыг сайжруулах хэрэгцээ байна. Тухайлбал, төрийн зүгээс холбогдолтой хууль эрх зүйн орчин, дэмжлэг урамшууллын боломжуудыг талуудад тогтмол түгээх, мэргэжлийн байгууллагууд нь аргачлал, арга зүйн холбогдолтой мэдээлэл сургалтаар хангах, бизнес эрхлэгчид нь өөрийн байгууллагад бий болсон сайн туршлага, нөлөөллийн ажлуудыг бусдад хуваалцдаг байх нь чухал юм.

Бизнес эрхлэгчдэд хамгийн хэрэгцээтэй сургалт зөвлөх үйлчилгээ нь тогтвортой ногоон санхүүжилтийн асуудал болон хог хаягдлыг ангилах, дахин боловсруулах, үйлдвэрлэл үйлчилгээний талаарх мэдээлэл байна. Хог хаягдлын менежмент, үйлдвэрлэл, үйлчилгээний холбогдолтой сургалтад хамгийн их хувьтай хамрагдаж байсан ч цаашид мөн энэ чиглэлээрх сургалтад хамрагдах хэрэгцээ шаардлага өндөр гэсэн нь тухайн сэдвийн ач холбогдол бизнес эрхлэгчдэд өндөр байгааг харуулж байна. Сургалт, зөвлөх үйлчилгээ зохион байгуулах тохиромжтой аргууд нь бизнес эрхлэгчдийн байршлаас хамааран бага зэрэг өөр байна. Хөдөө орон нутгийн бизнес эрхлэгчид илүү нүүр тулсан, биечилсэн арга замаар сургалт, зөвлөх үйлчилгээ авах нь үр дүнтэй гэж үзсэн бол Улаанбаатар хотод байршилтай бизнес эрхлэгчид зайны (онлайн, утас гэх мэт) аргуудыг түлхүү санал болгосон.

6. Хавсралтууд

Хавсралт 1—Сайн жишээ болох кейсүүд

Кейс Судалгаа 1

JAMOGRAND LLC, Ерөнхий Менежер Б. Дуламсүрэн /99022507/

Хөвсгөл, Тэрэлж, Өмнөговьд 3 жуулчны баазтай аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулдаг гаднын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж.

Үйл ажиллагаандаа **5R** зарчмыг хэрэгжүүлдэг.

Rethink - Бүх худалдан авалтын өмнө хог хаягдал бага гаргах бүтээгдэхүүн, түүхий эд материал сонгодог. Бүх захиалга дээрээ үйл ажиллагаа жигдрүүлэхэд тустай байгаа эсэхийг бодолцож шийдвэр гаргадаг.

Reuse - Нийлүүлэгч нараас одоо зөвхөн АПУ-аас л ус ундаа, шингэн хүнсээ авч байгаа, учир нь зөвхөн АПУ л бүтээгдэхүүний саваа дахин авдаг.

Repurpose - 2019 онд дэлгүүрээ барихдаа хаягдал ашигласан, жуулчдад их таалагддаг.

Reduce - Бүх агуулахаа сулласан, юуг ч хадгалдаггүй, зөвхөн хэрэгтэй зүйлээ худалдаад илүүг нь борлуулдаг, хотод 3 агуулах байсан, одоо нэг л гарааш байгаа. Бааз дээрх агуулахаа сулласан ба агуулахгүй болчихоор хог хаягдал багассан.

Recycle – Хуучин дахиврыг сайн ялгадаг байсан, 2 жил ялгасан боловч 2019 оноос хойш дахин ангилахаа больсон. Учир нь ажил болж ангилсан хогоо ачуулахад хогийн машин бусад хогтой хольж аваачаад асгадаг тул утгагүй болж ирсэн. Тиймээс хаягдлын агуулах нээгээд зөвхөн хуванцар болон шилээ ангилаад өөрсдөө аваачиж тушаадаг болсон.

Хамгийн их хаягдал ус ундааны савнаас гардаг. Тиймээс жуулчид амрагчдад аль болох нэг удаагийн савтай цэвэр усыг санал болгохгүй, нийтийн ус цэвэршүүлэгч буюу диспенсерээс өөрийн савандаа дүүргэж авахыг зөвлөдөг. Гэвч ковидтой холбоотой ялангуяа гадаадын жуулчдын айдас /диспенсерээс ус дүүргэхдээ заавал цоргонд саваа хүргэж байж ус нь гоождог/ арилаагүй байгаа тул одоогоор бүрэн хэрэгжихгүй байна.

Хогийн савыг тэгж их байрлуулдаггүй, хогийн сав байршуулах нь зөв шийдэл биш болох нь харагдсан. Учир нь хогийн саванд хийхээр хүмүүс хог гэж хараад, бусад хогтой холилдож, дахин ашиглах боловсруулах боломжгүй болно. Харин хогийн сав байхгүй болохоор хог гэж харахгүйгээр өөрөөр хүлээж авдаг болсон.

Байгаль орчин, аюулгүйн ажиллагааны зааварчилган дээр 5R-ын зааварчилгаа өгдөг ба ажилчид нь хэрэгжүүлдэг болсон. Хогны талаар ажилчид санаачилга гаргавал урамшуулалтай байдаг. Одоогоор шинэлэг санаа гараагүй байгаа ч гадуур явагдаж буй сургалтуудыг их санал болгодог.

Хөвсгөл аймгийн Мөрөн хотод хог хаягдлын сургалт явагдаж байгаа ба дахивраа холиод байгаа тул хог авдаг тусгай өдөртэй болох санаачилга гарсан. Энэ санаачилга хэрэгжвэл баазуудад маш их хэрэгтэй.

Хөрсний бохирдлыг бууруулах, сэргийлэх арга замууд:

Хөрс хамгийн ихээр бохирдуулж буй эх үүсвэр нь машин зам бөгөөд замын тэмдэглэгээ хийсэн боловч хүмүүс өөр өөрсдийн замаар зорчиж бааз руу ирдэг. Тиймээс аль болох баазын эргэн тойрон болон бааз дотроо олон салаа зам гаргахаас сэргийлэх бүх арга хэмжээг авч байна. Жишээ нь, бааз дотроо явган замууд тавьдаг, бааз тойруулаад машин замаа хязгаарлаад нэг л зам гаргаад ард нь

цементэн зогсоол гаргасан ба машин угааж хөрс бохирдуулах нь багассан. Гэвч говьд бол газар бага зэрэг гэмтэхэд л шороо босдог тул мод тарьж байгаа, тэр дундаа аль болох унаган мод тарьдаг.

Эрчим хүч хэмнэх арга замууд:

2019-2021 онд баазууд дээрээ бүтэн засвар хийж, 10 цагаас дээш буюу тогийн хэмнэлтэй ламп суулгасан. Мөн гэрлээ унтраа гэдэг санамж унтраалга болгоны доор байрлуулсан. Мөн шүршүүр, усны крант бүрийн доор ус хэмнэх зааварчилгаа байдаг. Аяга таваг угаахдаа Standard Operating Procedure (SOP) хэмээх зураг дүрслэл бүхий тусгай дарааллын дагуу ажилладаг ба шинэ ажилтанд энэхүү зааварчилгааг Менежер танилцуулж, дадлага хийлгэн зааж сургадаг.

Хог хаягдлыг бууруулахад тулгамдаж буй асуудал:

Дахиврыг ачуулах, тушаах явц хүртээмжгүй байна. Жишээ нь, "Царцаа ногоон" дахивар авах үйлчилгээг дуудах гэхээр холбоо барих мэдээлэл байхгүй, accessible биш.

Түүхий эдийн сав баглаа боодлыг хянахад хүндрэлтэй. Хүнсний бүтээгдэхүүнийг том савлагаатай авбал муудна, жижиг савлагаатай бол хүнсний хаягдал багатай, томоор авч болох гурил будаа зэрэг цөөхөн бүтээгдэхүүнээ том савлагаатай авдаг. Гэвч дийлэнх нь жижиг савлагаатай ирдэг ба шил лааз бол ерөнхийдөө хог болж байна.

Хүнсний хог хаягдлаа компаст болгохоор оролдож үзсэн. Гэвч ажиллагаа ихтэй бөгөөд тогооч нарыг бэлтгэнэ гэдэг тогооч нарын ажлын байр хамгийн их тогтворгүй байдаг аялал жуулчлалын салбарт бол зөв шийдэл байж чадахгүй. Хуучин хүнсний хаягдлаа малд өгдөг байсан, гэвч бог мал түүнийг иддэггүй тул байгальд хог болж үнэр гардаг.

Ус хэмнэх санаачилгад тулгамдаж буй асуудал:

Тус компанийн баазууд гаднаа усан бассейнтай бөгөөд бассейны усаа цэвэршүүлээд дахин ашиглаж тарьсан модоо услах зорилгоор саарал усны систем судалж байгаа ч Монголд боломж нь тун хомс байна. Учир нь, саарал ус хийдэг 11 газартай уулзсанаас 10 газар нь саарал ус гээд яриад байгаа нь тийм бодитой бус, мод услахад тохиромжгүй гэж хариулсан. Эдгээр байгууллага зөвхөн ногоон зээлд хамрагдахын тулд л саарал ус хийдэг ба саарал усыг дахин ашиглах ойлголт бодит амьдрал дээр хэрэгждэггүй аж. Ийнхүү бассейнаас гарч буй усыг дахин ашиглах оролдлого бүтэхгүй учир бууж өгсөн бөгөөд одоо европын болон олон улсын компаниудыг судалж байгаа. Угтаа бол цэвэршүүлсэн усаараа жимсний мод услах, мал услах, 00-д ашиглах зэргээр дахин ашиглавал сайн боловч ус цэвэршүүлэх технологи нь маш их зардалтай, ээлтэй шийдэл Монголд байхгүй гэж үзэж байна.

Салбарын ерөнхий чиг хандлагын талаар:

Аялал жуулчлалын салбар бол бусад салбартай харьцуулахад илүү байгальд ээлтэй үйл ажиллагаа явуулах эрмэлзэл маш өндөр байдаг. Компаниудын дор хаяж нэг хүн нь экологийн чиглэлээр санаа зовдог хүн байдаг. Дийлэнх тур оператор, жуулчны баазууд хаврын сургалт дээрээ бүх ажилтнууддаа хог хаягдлын талаар мэдээлэл өгдөг. Нөгөө талаас жуулчид ч мөн байгаль ээлтэй аялахыг хүсдэг болсон тул энэ хоёрыг нэг түвшинд аваачихын тулд сургалт хийдэг.

Байгальд ээлтэй, нөөцийг хэмнэсэн, дахин ашиглах шийдлүүдийг хэрэгжүүлэхэд хөрөнгө шаардагддаг тул санхүүгийн чадавхтай компаниуд л хэрэгжүүлдэг. Ерөнхийдөө Монголд 3 түвшний баазууд байна: (1) өндөр зэрэглэлийнх тул хөрөнгө гаргах боломжтой, үйлчлүүлэгчид (уг компанийн үйлчлүүлэгчдийн 80 хувь нь гадаадын жуулчид байдаг ба ихэвчлэн боловсрол өндөртэй, аялж сурсан хүмүүс ирдэг) нь ч илүү мөнгө төлдөгтөө сэтгэл хангалуун байдаг. (2) дунд зэрэглэлийн баазууд бол сайн жишээнээс суралцаад явж байгаа, ирж танилцдаг. (3) эко баазууд бол явуулын болон монгол аялагчид ихээр амардаг тул хог хаягдал их гаргадаг. ТЭЗ-ийг дэмжихийн өндөр зэрэглэлийн баазууд

санхүүгийн чадавхтай тул тэднээс эхэлж нэвтрүүлээд дараа нь бусад руу нь чиглүүлбэл үр дүнтэй гэж үзэж байна.

Кейс Судалгаа 2

DMD ХХК, Ерөнхий Захирал Ж.Соёлмаа /77115534/

Ямар ч бетонон байгууламжгүй, байгальд ээлтэй, жинхэнэ монгол хэв маяг бүхий нүүдлийн гэр буудлуудыг Элсэн тасархай болон Өвөрхангай аймагт ажиллуулдаг, Франц болон Европын бусад улсаас жуулчин хүлээн авдаг, гадаадын хөрөнгө оруулалттай /50 хувь нь Францаас/ тур оператор компани. Байгаль ээлтэй үйл ажиллагаа явуулдаг гэсэн олон улсын шагнал болон МХАҮТ-аас олгодог "Ногоон Буудал" эко шошго авсан.

Хог хаягдлыг бууруулах шийдэл:

Хуванцар зүйл ашиглахаас татгалздаг. Гэр буудлын тохижилт, эд хэрэглэл гээд бүх зүйл нь модон болон байгалийн гаралтай материалаар хийгдсэн байдаг.

Гэр буудал дээрээ хогийн сав байрлуулдаггүй.

Гарч буй хог хаягдал нь ихэвчлэн түүхий эд материалын сав баглаа боодол байдаг. Аль болох том савлагаатайг авдаг ба сав боодлыг ангилж, тухайн орон нутгийн хогийн цэгүүдэд тушаадаг ч орон нутагт гарсан эдгээр хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрт очдог эсэх нь тодорхойгүй.

Цэвэр усыг жижиг савлагаагаар бус ихэвчлэн 5 литрийн савлагаатайг авч, жуулчдад дахин ашиглах усны сав өгдөг. Харин 5 литрийн усны сав нь хаягддаггүй, тухайн орон нутгийн цагаан идээ ханган нийлүүлэгч малчин өрхүүдэд дахин ашиглагдаж /айраг, сүү хийх, г.м./, эргэлтэд ордог.

Ус хэмнэх шийдэл:

Ус хэмнэлтээрээ нэлээд жишиг болсон гэр буудал. Тухайлбал, жуулчид өөрсдөө шүршүүрт орохгүйгээр гэр гэрт нь алжаал тайлах үйлчилгээ болох эфирийн тосонд жигнэсэн алчуураар биеийг нь арчих, үсийг нь угааж өгөх замаар усаа хэмнэдэг. Тухайн баазад буудаллаад явсан жуулчин хамгийн ихдээ 5 л ус л зарцуулдаг ба байгаль ээлтэй гэдэг мессежийг өгснөөр жуулчид илүү сонирхдог, бас байгальд ээлтэй аяллыг улам бүр сонирхох болсон Европ жуулчдын хэрэгцээ сонирхолд нийцдэг.

Хөрсний бохирдлоос хамгаалах шийдэл:

Уг нүүдлийн гэр бааз нь нүхэн жорлонгоо ямар ч химийн бодисгүй, байгалийн аргаар хөрсөнд ямар ч нөлөөгүйгээр шийдсэн. Өөрөөр хэлбэл, жорлонгийн нүхээ 1,4 м ухаад шингэнийг шүүх шүүх /өтгөн, шингэнийг ялгах/ зорилгоор сүрэл дэвсээд, дээр нь "үртэс хийж, 00-ын цаас зэрэг өөр ямар ч зүйл хийдэггүй ба энэ нь ямар ч үнэргүй, хөрс нь эргээд бор шороо буюу бордоо болдгоороо давуу талтай аж.

Эрчим хүч хэмнэх шийдэл:

Жуулчдын байрлах гэрүүдэд цахилгаан огт байхгүй, утаагүй түлшээр зуухаа халаадаг.

Орон нутгийн хөгжлийг дэмжих:

Үйл ажиллагаа явуулдаг орон нутгийнхаа малчин иргэдийн амьжиргааг дэмжих, мөн жуулчдад орон нутгийн гар урлал, бэлэг дурсгалын бүтээгдэхүүн борлуулах зорилгоор эсгий урлалын дизайнер Францаас урьж 10 гаруй хүнд сургалт явуулж, тэдгээр хүмүүс одоо хүртэл өөрсдийн урласан бүтээгдэхүүнээ тус баазын дэлгүүр нийлүүлдэг.
